




“ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН АМЬТНЫ ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ, ТЭДГЭЭРИЙН ТАРХАЛТ ЭЛБЭГШИЛ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН



ДАРЬГАНГА 2013

ЗАХИАЛАГЧ:

**ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА**

**“ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН АМЬТНЫ ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ,
ТЭДГЭЭРИЙН ТАРХАЛТ ЭЛБЭГШИЛ”
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Гүйцэтгэсэн:

**МУИС, ББС-ийн Экологийн
тэнхимийн магистрант
С.Түвшинтөгс**

Хамтран гүйцэтгэсэн:

**Дарьгангын БЦГ хамгаалалтын
захиргаа**

**В.Сүхбаатар
Д.Ариунцэцэг
Н.Оюунгэрэл
С.Мажигсүрэн
Ц.Намжвандан
Г.Мөнхболд
Ж.Ганбаатар**

ДАРЬГАНГА 2013

ГАРЧИГ

Удиртгал	4
Судалгааны зорилго, зорилт	4
Судалгааны материал, арга зүй	5
Судлагдсан байдал	7
Судалгааны үр дүн	8
Дарьгангын байгалийн цогцолборт газрын хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл	8
Дарьгангын байгалийн цогцолборт газарт тохиолдох Монгол улсын улаан номонд орсон амьтад	13
Дарьгангын байгалийн цогцолборт газарт тохиолдох бусад хөхтөн амьтад	17
Дарьгангын байгалийн цогцолборт газрын Цагаан зээрийн тархац, нөөцийн судалгаа	41
Дарьгангын байгалийн цогцолборт газрын Монгол тарваганы тархац, нөөцийн судалгаа	43
Дарьгангын байгалийн цогцолборт газрын жижиг хөхтөний зүйлийн бүрдэлийн судалгаа	47
Дарьгангын байгалийн цогцолборт газрын шувуудын зүйлийн бүрдэлийн эмхтгэл	49
Дүгнэлт	54
Санал, зөвлөмж	55
Ашигласан бүтээл	56

УДИРТГАЛ

Сүхбаатар аймгийн Дарьганга, Наран сумдын нутгийг дамнан оршдог Дарьгангын байгалийн цогцолборт газар болон Шилийн Богдын дурсгалт газар орчмын амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархалт элбэгшлийн судалгааг 2013 оны 9 сарын 25-аас эхлэн гүйцэтгэж байна.

Уур амьсгалын өөрчлөлт болон хүнээс шалтгаалсан сөрөг нөлөөлөлөөс үүдэн зэрлэг амьтдын тархалт, элбэгшил, зүйлийн олон янз байдал буурч амьдрах орчин хумигдаж байна. Иймд аливаа судалгаа шинжилгээний ажлаар тэдгээрийн экологи, биологи нь шинэ мэдээгээр баяжигдахын сацуу одоогийн болоод ирээдүйн хамгааллын менежментэнд ашиглах боломж бүрддэг тул энэхүү судалгаа хийгдэх үндэслэлийн нэг билээ. Мөн энэ бүс нутагт урьд нь амьтны цогц судалгаа тусгайлан хийгдэж байгаагүй нь хоёрдогч үндэслэл болж байна.

Дээр дурьдсанаар уг судалгааны ажил нь Дарьгангын байгалийн цогцолборт газарт тархсан жигүүртэн, хоёр нутагтан, хөхтөн амьтдыг бүхлээр нь багтаасан анхдагч судалгаа болж байгаагаараа онцлогтой. Тус судалгааны анхны санал “Цогцолборт газрын зэрлэг амьтдын байршил тогтоох” гэсэн ерөнхий судалгаа байсан бөгөөд үүнийг суурь болгож нэмэлт судалгаануудаар баяжуулж тус газарт тархсан хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл, тархалт элбэгшлийг үнэлж, мэдээллийн болоод экологи, биологийн үр дүнтэй ажил хийхээр зорьсон болно.

Судалгааны зорилго: Дарьгангын байгалийн цогцолборт газрын амьтны зүйлийн бүрдэлийг тогтоох, зарим амьтдын тархац нөөцийг үнэлэх

Судалгааны ажлын зорилт:

- Цогцолборт газарт тархсан зэрлэг амьтдын зүйлийн бүрдлийг тогтоож, тэдгээрийн тархалт байршилыг тогтоох
- Мөн тус бүс нутагт тархсан монгол тарвага, цагаан зээрийн тархац, нөөцийг үнэлэх
- Амьдрах орчны ялгаатай хэв шинжүүд дэх жижиг хөхтөн амьтны зүйлийн бүрдэлийг гаргах
- Дарьганга орчмын шувуудын зүйлийн бүрдлийг хэвлэгдсэн бүтээлээс шүүж хээрийн судалгааны явцад бүртгэсэн зүйлүүдтэй нэгтгэж нэгдсэн жагсаалт гаргах

СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Дарьгангын байгаийн цогцолборт газарт судалгааг 2013 оны 9 сарын 25-аас эхлэн, Талын –Ухаа, Шилийн богд, Нарт, Молцог элс, Өлзийт булаг, Дуут нуур, Ганга нуур зэрэг газруудад ажиллаа. Хээрийн судалгааны цэгүүдэд замналын аргаар явж тохиолдсон амьтдын зүйлийг Nikon 40x маркын зургийн аппарат, дуран, GPS зэргийг ашиглан, бүртгэж баталгаажуулсан. GIS, Google earth програм дээр тэдгээр амьтдын тархалтын зургыг гаргасан. Мөн хэвлэгдсэн бүтээлээс тус газарт тархсан зүйлүүдийг бүртгэж Цогцолборт газрын хэмжээнд тохиолдох боломжтой нийт хөхтөн амьтдын зүйлийн бүрдлийг жагсаалтаар гаргаж тус бүрийх нь дэлгэрнгүй тайлбар, Дарьганга орчим дахь байршил тархалтыг тодорхой тусгаж өглөө.

Цагаан зээрийн судалгааг тус сумын орон нутгийн тусгай хамгаалалтанд байдаг Нарт уул орчимд хоёр удаагийн давталттайгаар, экологийн судалгааны талбайн аргаар байршил, нөөцийг үнэлэв.


Монгол тарваганы судалгааг Хамгаалалтын захиргааны хяналтанд байдаг, энэ бүс нутгийн монгол тарваганы сүүлчийн нөөц тархсан Энгэрийн-Ухаа, Талын-Ухаа, Тариалан, Улаан уул, Шилийн Богд уул зэрэг газарт тархалт нөөцийн судалгааг хийв. Зөвхөн дээр дурдагдсан газруудад монгол тарвага тархаж байгаа нь мэдэгдэж байгаа учир GPS ашиглаж тухайн газар нутагт тохиолдох тарваганы идэвхитэй дош, ичээг бүртгэн, тархалтын хамгийн захын цэгүүдийг тэмдэглэн тархалтын талбайн нийт хэмжээ, талбайд тохиолдох дошны нягтшилыг гаргасан. Дош бүр дэх бүлийн тоог сүүлийн үед хийгдсэн ижил төстэй судалгааны дундаж үр дүнг ашиглаж Дарьгангын байгалийн цогцолборт газрын монгол тарваганы нөөцийг үнэлэв.

Дарьганга орчмын шувуудын зүйлийн бүрдлийг өмнө хийгдсэн судалгааны хэвлэгдсэн бүтээлээс шүүж жагсаалт гаргасан ба жагсаалт дээрээ хээрийн судалгааны явцад (Зураг 1) бүртгэсэн шувуудын зүйлүүдийг нэмж нэгдсэн жагсаалт гаргасан. Уг жагсаалтаас ховор, суурин, өндөглөн зусдаг, нүүдлийн үедээ тохиолддог, өвөлждөг шувуудыг тус тус ангиллаа.




Зураг 1. Судлаач, байгаль хамгаалагч нар Ганга нууранд шувуу ажиглах цамхагаас шувуудын бүртгэл, тооллого хийж байгаа нь.

Жижиг хөхтөн амьтны зүйлийн бүрдэлийн судалгааг амьдрах орчны ялгаатай биотопуудаар төлөөлүүлэн Молцог элс, Намжил бүрдийн нуга, Дуут нуур орчимд хээрийн хэв шинж бүхий амьдрах орчнуудыг сонгож, 20 метрийн урт, 25 см өргөн, 30 см гүн шуудуу ухаж тус бүрт нь 20 см диаметртэй конус 2 ширхэгийг суулгаж жижиг хөхтөн амьтадыг дээжинд авлаа (Зураг 2). Дээжинд баригдсан амьтадыг их биеийн урт, чихний өндөр, тавхайн урт, сүүлний урт зэрэг хэмжилтүүдийг хийж арьсыг өвчиж хатааж, толгойн ясыг цэвэрлэж арааны шүдний бүтцээр тухайн амьтныг зүйлийн түвшинд тодорхойлсон.



Зураг 2. Ялгаатай хэв шинж бүхий биотопууд ба жижиг хөхтөн амьтан барих шуудуу ухаж байгаа нь. (А) Намжил бүрд орчмын нугат бүлгэмдэл, (Б) Дуут нуур орчмын хээрийн бүлгэмдэл, (В) Молцог элсний бүлгэмдэл, (Г) Дарьгангын БЦГ-н албан хаагчид жижиг хөхтөн амьтан барих шуудуу ухаж байгаа байдал.



Зураг 3. (А) Жижиг хөхтөн амьтан унагаж барих шуудуу ухсан байдал. (Б) Шуудуунд ухаж суулгасан конус, (В) Шуудууны ерөнхий бүтэц

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Дарьгангын байгалийн цогцолборт газарт тусгайлан хөхтөн амьтдын судалгаа хийж байгаагүй. Гадаад дотоодын судлаачид Дарьганга орчмоор дайрч өнгөрөх үедээ амьтны аймгийн талаар ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөн түүнийгээ тайлан, өгүүлэлдээ цухас дурдсан байдаг. Хэвлэлийн мэдээллийг шүүж үзэхэд Дарьганга орчмын нутгаар 6 баг 13 овог 31 төрөлд хамаарах 40 орчим зүйл хөхтөн амьтан байршдаг байна гэж Г.Сүхчулуун (2012) “Дарьгангын байгалийн цогцолборт газар, Шилийн богд, Хөргийн хөндийн дурсгалт газрын хөхтөн амьтад” илтгэлдээ дурьджээ. Үүнээс харвал тус бүс нутагт хөхтөн амьтдын судалгаа тун бага хийгдэж байсан бөгөөд монгол орон, бүс нутгийг хамарсан томоохон хэмжээний судалгааны явцад тус газар нутгийн зарим хэсэг хамрагдах маягаар судалгаа хийгдэж байсан байна. Жишээ нь: 1999-2001 онд хэрэгжсэн Дорнод Монголын биологийн төрөл зүйл төсөл, Монгол орны тал хээр, говь цөлийн тууртны нөөцийг тогтоох зорилгоор 2009 онд хийгдсэн судалгаа зэргийг дурьдаж болно.

Дарьгангын байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөө (2013-2017)-д тус газрын аймтны аймгийн талаар тодорхой мэдээлэл тусгаагүй бөгөөд зарим ховор амьтдыг дурьдах төдийхнөөр оруулжээ. Мөн түгээмэл тархсан хөхтөн амьтдын 15 зүйлийг оруулсан нь учир дутагдалтай боловч тус газар нутагт хийгдсэн зэрлэг амьтны судалгааны ажил хомс байгаатай холбоотой. Хоёр нутагтан ба мөлхөгчидөөс Монгол бах (*Bufo raddei*), дорнодын мэлхий (*Rana chensinensis*), цоохорхонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*), монгол гүрвэл (*Eremisa argus*), рашааны могой (*Elephas dione*), сум могой (*Psammopus pilineolatus*) зэрэг 7 зүйл бүртгэгдсэн байна. Мөн 111 зүйл шувуу бүртгэгдсэнээс 12 зүйл нь суурин, 99 зүйл нь нүүдлийн шувууд байна гэсэн үр дүнг гаргасан байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дарьгангын хөхтөн амьтдын зүйлийн бүрдэл

Дарьгангын байгалийн цогцолборт газарт тохиолдох боломжтой хөхтөн амьтдыг хэвлэгдсэн бүтээлээс шүүж үзэхэд Е.Л.Сларк нарын (2006) “Монгол улсын хөхтөн амьтдын улаан данс” номонд Дарьганга орчимд 33 зүйл амьтан, Н.Батсайхан нарын (2010) “Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага” бүтээлд 35 зүйл амьтан тохиолдох боломжтойг харуулсан байна. “Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага” номыг “Монгол улсын хөхтөн амьтдын улаан данс” номтой харьцуулж үзвэл Шар чичүүл (*Meriones meridianus*), Элсч савагдаахай (*Dipus sagittal*), Цомч шийшүүхэй (*Allocricetulus curtatus*), Гэрийн хулгана (*Mus musculus*) зэрэг 4 зүйл жижиг мэрэгч амьтан энэ бүс нутагт нэмж тархах боломжтойг харуулсан бол нэг зүйл туруутан Хар сүүлтзээр (*Gazella subgutturosa*) мөн нэг зүйл гар далавчтан Дорны сармаахай (*Vespertilio superans*) тохиолдох боломжгүй гэж үзсэн байна.

Судалгааны ажлаар Дарьгангын байгалийн цогцолборт газарт том хөхтөн амьтан болоод гар далавчтан, махчин, мэрэгч, амьтдын 7 баг, 15 овог, 19 төрөлд хамаарах 20 зүйл амьтныг бүртэглээ (Бүртгэсэн амьтдын дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1). Эх сурвалжуудад энэ нутагт тэмдэглэгдээгүй Аргаль (*Ovis ammon*), Хулан (*Equus hemionus*) зэрэг 2 зүйл хөхтөн амьтдыг судалгаагаар бүртгэсэн бөгөөд Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) өвлийн улиралд тус бүс нутагт цөөн тооны сүргээр нүүдэллэн орж ирдэгийг тогтоосон.

Хэвлэгдсэн бүтээл болон энэхүү судалгааны ажлын явцад бүртгэсэн амьтдын зүйлүүдийг нэгтгэвэл Дарьгангын байгалийн цогцолборт газрын хэмжээнд 39 зүйл амьтан тохиолдох боломжтой байна (Хүснэгт 2).

Хүснэгт 1. Дарьгангын байгалийн цогцолборт газарт судалгааны явцад бүртгэсэн хөхтөн амьтдын зүйлийн жагсаалт.

	Баг	Овог	Монгол нэр	Латин нэр	Тоо	Амьдрах орчин
1	Мэрэгчтэн	Scuiridae	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	2	Хээр
2		Scuiridae	Дагуур зурам	<i>Spermophilus dauricus</i>	10<	Хээр
3		Dipodidae	Сибир алагдаага	<i>Allactaga sibirica</i>	3	Хээр
4		Gerbilidae	Монгол чичүүл	<i>Meriones unguiculatus</i>	10<	Хээр
5		Muridae	Гэрийн хулгана	<i>Mus musculus</i>	10<	Хээр
6		Arvicolinae	Үлийн цагаан оготно	<i>Lasiopodomys brandti</i>	5	Хээр
7		Cricetidae	Цомч шийшүүхэй	<i>Allocricetulus curtatus</i>	2	Хээр
8		Cricetidae	Шийшүүхэй	<i>Cricetulus sp</i>	1	Нуга
9	Туулайтан	Ochotonidae	Дагуур огдой	<i>Ochotona dauurica</i>	20<	Хээр, элс
10		Leporidae	Бор туулай	<i>Lepus tolai</i>	4	Хээр, элс
11	Зараатан	Erinaceidae	Дагуур зараа	<i>Mesechinus dauuricus</i>	2	Хээр
12	Махчтан	Felidae	Мануул	<i>Otocolobus manul</i>	1	Хээр
13		Canidae	Саарал чоно	<i>Canis lupus</i>	7	Хээр
14		Canidae	Хярс	<i>Vulpes corsac</i>	1	Хээр
15		Canidae	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	3	Хээр
16	Туурайтан	Equidae	Хулан	<i>Equus hemionus</i>	1	Хээр
17	Туруутан	Bovidae	Аргаль	<i>Ovis ammon</i>	10	Хээр
18		Bovidae	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	1000<	Хээр
19		Cervidae	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	3	Хээр
20	Гар далавчтан	Vespertilionidae	Багваахай	<i>Myotis sp</i>	1	Хээр

Хүснэгт 1. Дарьгангын байгалийн цогцолборт газарт тохиолдох амьтдын жагсаалт болон тэдгээрийн олон улсын болон бүс нутгийн хэмжээнд үнэлсэн статусыг харуулав. БНС-Бүс нутгийн статус, ОУС-Олон улсын статус, * - ангилалд хамаарах тэмдэг

	Монгол нэр	Латин нэр	Устаж болзошгүй		Эмзэг		Ховордож болзошгүй		Мэдээлэл дутмаг		Анхааралд өртхөөргүй	
			БНС	ОУС	БНС	ОУС	БНС	ОУС	БНС	ОУС	БНС	ОУС
1	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	*									*
2	Дагуур зурам	<i>Spermophilus dauricus</i>							*			*
3	Сибир алагдаага	<i>Allactaga sibirica</i>									*	*
4	Хөх шийшүүхэй	<i>Cricetulus barabensis</i>									*	*
5	Орог зусаг	<i>Phodopus campbelli</i>									*	*
6	Хадны барагчин	<i>Alticola semicanus</i>									*	*
7	Сохдой оготно	<i>Ellobius tancrei</i>									*	*
8	Үлийн цагаан оготно	<i>Lasiopodomys brandti</i>									*	*
9	Хэргэлзий оготно	<i>Microtus gregalis</i>									*	*
10	Монгол чичүүл	<i>Meriones unguiculatus</i>									*	
11	Гэрийн хулгана	<i>Mus musculus</i>										
12	Дагуур огдой	<i>Ochotona dauurica</i>									*	*
13	Бор туулай	<i>Lepus tolai</i>									*	
14	Дэлдэн зараа	<i>Hemiechinus auritus</i>									*	*
15	Дагуур зараа	<i>Mesechinus dauuricus</i>									*	*
16	Малтаахай	<i>Crocidura sibirica</i>									*	*
17	Сахалт багваахай	<i>Myotis mystacinus</i>									*	*
18	Бор соотон багваахай	<i>Plecotus ognevi</i>									*	*
19	Буурал сармаахай	<i>Vespertilo murinus</i>									*	*
20	Дорны сармаахай	<i>Vespertilo superans</i>							*			*
21	Мануул	<i>Otocolobus manul</i>					*	*				
22	Саарал чоно	<i>Canis lupus</i>					*					*
23	Загал элбэнх	<i>Nyctereutes procyonoides</i>									*	*
24	Хярс	<i>Vulpes corsac</i>					*					*
25	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>					*					*
26	Мангис дорго	<i>Arctonyx collaris</i>							*			*

27	Халздай дорго	<i>Meles meles</i>									*	*
28	Солонго үен	<i>Mustela altaica</i>									*	*
29	Цагаан үен	<i>Mustela erminea</i>									*	*
30	Өмхий хүрэн	<i>Mustela eversmannii</i>									*	*
31	Хотны үен	<i>Mustela nivalis</i>									*	*
32	Хулан	<i>Equus hemionus</i>	*			*						
33	Хар сүүлт	<i>Gazella subgutturosa</i>			*	*						
34	Аргаль	<i>Ovis ammon</i>	*			*						
35	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	*									*
36	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>									*	*
37	Цомч шийшүүхэй	<i>Allocricetulus curtatus</i>									*	*
38	Шар чичүүл	<i>Meriones meridianus</i>									*	*
39	Савагдаахай	<i>Dipus sagitta</i>									*	*
	Бүгд		4			3	4	1	3		26	32

Дарьгангын байгалийн цогцолборт газарт тохиолдох 39 зүйл амьтадаас олон улсын хэмжээнд 36 зүйл нь үнэлэгдсэн бол бүс нутгийн хэмжээнд 38 зүйлийг үнэлсэн байна. Үүнийг тус тусд нь графикаар харуулвал (График 1 ба 2).




График 1. Дарьгангын байгалийн цогцолборт газрын амьтны зүйлүүдийн бүс нутгийн хэмжээнд үнэлэгдсэн хувь.

Цогцолборт газар тархсан нийт амьтдын 68% нь бүс нутгийн хэмжээнд анхааралд өртхөөргүй, 10% нь устаж болзошгүй, 11% нь ховордож байгаа, 8 % нь мэдээлэл дутмаг 3% нь эмзэг гэсэн ангилалд хамаарагдаж байна. Үүнээс харвал тус газарт тархсан нийт амьтдын 24% нь бүс нутгийн хэмжээнд ховордлын зэрэгт хамаарах зүйлүүд байна.




График 2. Дарьгангын байгалийн цогцолборт газрын амьтны зүйлүүдийн олон улсын хэмжээнд үнэлэгдсэн хувь.

Дээрх графикаас харвал Цогцолборт газар тархсан нийт амьтдын 89% нь олон улсын хэмжээнд анхааралд өртхөөргүй, 3% нь ховордож байгаа, 8% нь эмзэг гэсэн ангилалд хамаарагдаж байна. Үүнээс харвал тус газарт тархсан нийт амьтдын 11% нь олон улсын хэмжээнд ховордлын зэрэгт хамаарах зүйлүүд байна.

ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР ТОХИОЛДОХ МОНГОЛ УЛСЫН УЛААН НОМОНД ОРСОН АМЬТАД

Монгол хулан *Equus hemionus* Pallas, 1775

Биеийн галбир, хэмжээ, зүс: Монгол хулан хул хонгор зүстэй, улирал болон бодгалаас хамаарч ухаа хонгор, цайвар хул, бор хул зүстэй ч тохиолдоно. Хэвлий, цавь, суга гуяны зураа орчим цайвир зүстэй. Мундаанаас зоо нуруу дагуу сүүлний цацаг хялгас хүртэл бор тууш хүрэн судалтай. Дэл босоо, ахар, хар өнгөтэй, сүүлний годонгийн төгсгөлд хар бараан цацаг хялгастай. Толгой данхар, урт чихтэй, мөч чацархаг. Биеийн урт 200-260 см, мундаа орчим чац нь 110-140 орчим см, чихний урт 17.5-26.5 см, биеийн жин 200-300 кг хүрнэ.

Амьдралын онцлог: Ороо нийллэг 7-р сараас 8-р сарын эцэс хүртэл үргэлжилнэ. Гүү 5-р сарын дунд үеээс 7-р сарын эх хүртэл төллөж, нэг унага төрүүлнэ. Хээлээ 340-342 орчим хоног тээнэ. Бадас 3-4 настай, харин үрээ 4-5 нас хүрж үржилд орно. Зун өглөө, орой, шөнийн цагаар, сэрүүн улиралд бараг өдрийн турш бэлчээрлэнэ. Үржлийн улиралд азарга сүрэг бусдаас тусгаар байх авч, ус бэлчээр хомс үед, эсвэл сэрүүн улиралд олон хулангийн сүрэг нэгдэж, хэдэн зуун бодгальтай том сүрэг бүрэлдэнэ. Азарга байх идвэхтэй нас нь 5-10 юм. Байгалийн нөхцөлд 14 насалдаг.

Амдрах орчин: Монгол орны цөл, цөлөрхөг хээрийн өдлөг хялгана-хөмүүл, баглуур-бударганат бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг, толгод, уудам хотос, хоолой, сайр, садарга, талбиу дэнжээр бэлчээрлэнэ. Задгай булаг, шанд, тойром шүтэх авч, задгай усгүй нутагт сайранд татаал гаргаж ундаална. Ус, бэлчээр дагаж, байнга шилжиж хөдөлдөг.

Дарьгангын байгалийн цогцолборт газарын Дуут нуур болон Алтан овоог тойрсон хамгаалалтын хашаанд адуутай ижилссэн нэг хулангийн гүү байршдаг. Энэ хулан Наран сумын нутагт айлын адуутай ижилссэн байсаныг 2010 онд хамгаалалтын захигаа тус газарт шилжүүлэн авчирч, уг ховор амьтныг хамгаалалтанд авсан байна (Зураг 27).



Зураг 27. Дарьгангын байгалийн цогцолборт газрын хамгаалалтанд байгаа хулангийн гүү. Зургийг С.Түвшинтөгс

Хар сүүлт зээр *Gazella subgutturosa* Guldenstadt, 1780

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн гадаад төрхөөхрөө цагаан зээртэй төстэй. Биеийн урт 110-116 см, сэрвээний өндөр 64-75 см, сүүлний урт 16-20 см, чихний урт 8-13 см, биеийн жин 18-33 килограмм. Сүүлний үзүүр хар, ооно 25-41 см урт эвэртэй. Ооно ба шаргачин хоёулаа хонгоны цагаан танатай. зүс нь улирлаар өөрчлөгдөх ба зунд улаавтар шаргал, цайвар шаргал өвөл цайвар шаргал. Хэвлий цагаан (Зураг 29).



Зураг 29. Хар сүүл зээр (*Gazella subgutturosa*) –ийн эм бодгаль. Зургийн эх сурвалж shiliinbogd.blogspot.com.

Амьдралын онцлог: Сүрэглэн амьдарна. Өвөл, намарт хэдэн зуугаараа сүрэглэнэ. Өвлөөс бусад улиралд өглөө оройд идээшлэх бөгөөд өвөлд өдөржин идээшлэнэ. Гэвч улирлын байдлаас хамаарч ус бэлчээрээ сэлгэн нүүдэллэнэ. элдэв зүйлийн өвслөг ургамал иднэ. Ороо хөөцөө 12-1 сарын хооронд болно. Хээл тээх хугацаа 180 хоног. Шаргачин 5-6 сард голдуу нэг янзага төрүүлнэ. Хоёр настайдаа үржилд орно. Байгалийн нөхцөлд 2 жил насална.

Амдрах орчин: Монгол орны цөлөрхөг хээр, цөлийн бутлаг, өвслөг ургамал бүхий аараг толгод, хөндий дагаж байршина.

Дарьгангад өвлийн улиралд нүүдэллэн цөөн тоогоор орж ирдэг. Зарим өвөл бэлчээр дагаж сумын төвийн захад хүртэл байршдаг. Харамсалтай нь туйлдсан бодгалиуд гэрийн нохойд бариулах нь элбэг (Зураг 29).



Зураг 29. Дарьганга сумын төвийн орчимд 2011 оны өвөл гэрийн нохойд бариулсан хар сүүлт зээрийн зэм. Зургийг Дарьгангын БЦГ

Аргаль *Ovis ammon* Linnaeus, 1758

Биеийн галбир, хэмжээ, зүс: Хүнд лагс биетэй, хөл харьцангуй урт. Биеийн урт 140-150 см, сэрвээний өндөр 120-125 см, угалз хомь хоёулаа эвэртэй. Угалзын эвэр мушгирсан хэлбэртэй бөгөөд урт нь 58-150 см урт эвэртэй, хааяа 170 см хүрнэ. Түүний эврийн угийн бүдүүн 40-44 см. Хомийн эвэр жижиг, 25-35 см урт, мушгий багатай. Угалз 40-200 килограмм, хомь 27-66 килограмм жинтэй. Зуны зүс хүрэвтэр бор, цайвар. Харин өвлийн зүс цайвар.

Амьдралын онцлог: Сүрэглэн амьдарна. Зун өглөө болон оройд, өвөлд өдөржин идээшлэнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамалууд, үет ургамал голдуу иднэ. Өвөлд сөөглөг ургамлын мөчир иднэ. Ус болон бэлчээрийн нөөцөөс хамаарагн байршлаа сэлгэнэ. Ороо хөөцөөнд 10 сард орно. хээл тээх хугацаа 150 хоног. Жилд нэг удаа төллөх ба ихэвчлэн нэг, хааяа ихэрлэнэ. Бэлэг боловсролт нь 2-3 настайгаас эхлэнэ. Байгалийн нөхцөлд 10-18 жил насална.

Амдрах орчин: Монгол орны уулархаг нутгийн хад асгат налуу, тагийн бүсийн дэвсгэрт байршин амьдарна.

Судалгаагаар тус сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газар Нартын ууланд 10 бодгальтай сүргийг бүртгэсэн (Зураг30). Сүргийн бүтэц нь 2 угалз, 3 хомь 3 хурга, 2 залуу аргалиас бүрдэж байсан. Энэхүү сүрэг нь тус газарт сүүлийн 8-9 жилд тогтвортой оршиж байгаа бөгөөд сүргийн тоо толгой өсөж байгаа хандлагатай байна. Мөн хаанаас нүүдлэн ирж суурьшсан мэдээ тодорхойгүй.



2011 оны өвөл тус газарт 2 угалз нэг дор үхсэн байсаныг нь Дарьгангын байгалийн цогцолборт газрын албан хаагчид олж илрүүлж толгойн ясыг нь авчирч хадгалсан байсан бөгөөд тус бүрт хэмжилт хийж нас, хүйс, зэрэг мэдээллийг дор оруулав (Зураг 31 ба хүснэгт 2).



Зураг 31. Нарт ууланд үхсэн угалзны толгойн яс. Зургийг С.Түвшинтөгс

Хүснэгт 2. Дарьгангын байгалийн цогцолборт газарт хадгалагдаж байгаа аргалийн толгойн ясны хэмжилтийн мэдээлэл.

№	Толгойн яс	Нас (Жил)	Хүйс	Эвэрний урт	Эвэр хоорондын зай	Эвэрний угын тойрог
1	Толгойн яс 1	12-13	Эр	91 см	6 см	41,5 см
2	Тулгойн яс 2	13-14	Эр	92 см	5,7 см	49 см

ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР ТОХИОЛДОХ БУСАД ХӨХТӨН АМЬТАД

Бор туулай *Lepus tolai* Pallas, 1778

Биеийн галбир, хэмжээ, зүс: Бор туулайн биеийн урт 390-580 мм, чихний урт 80-120мм, тавхайн урт 108-130 мм, биеийн жин 2800 грамм хүрнэ. Зуны зүс бор саарал, зоо нуруу боровтор шаргал, зулай, шанаа бор халтар, хэвлий цайвар саарал. Өвөл цайруу бор шарга, зоо нурууны сор үс бор хүрэн болдог. Чих урт гонзгой, үзүүр нь хар бараан. Сүүл ахар, дээд тал хар толботой, түүнийг тойрсон цагаан цайвар үстэй. Нүд бүлтгэр. Өмнөд мөч хойд мөчнөөс богино. Тавхай урт өтгөн үстэй (Зураг 4).



Зураг 4. Бор туулай (*Lepus tolai*). Молцог элсэнд 2013-8-3 өдөр тохиолдсон бодгаль. Зургийг С.Түвшинтөгс

Амьдралын онцлог: Бүрэнхий, шөнөөөр илүү идэвхтэй. Хад, чулууны хөндий, бут сөөг, тарвага үнэгний орхисон нүхэнд орогноно. Элдэв үетэн, алаг өвс, улалжийн ургал хэсэг, сөөгний залуу мөчир, нахиа үндэсээр голчлон хооллоно. Ороо нийллэг 3 сарын дунд үед болж, эм туулай хээлээ 42 хоног

орчим тээдэг. Жилд 2 удаа төллөх ба дундажаар 2-6 бүжин төрүүлдэг. Нэг настай үржилд ордог. Байгаль дээр 7 хүртэл жил наслана.

Амьдрах орчин: Бор туулай ойт болон уулын хээр, өндөр уулс, цөлөрхөг хээр, голын хөндий, нуур тойрмын дэрст хөвөө, элсэн довцог, сайр, жалга, голын шугуй зэрэг газрын сөөг, бут, хад чулуутай, далдац сайтай нутагт тохиолдоно.

Дарьганга орчимд альч газар түгээмэл тохиолдох элбэг зүйл. Судалгааны явцад Молцог элс болон Шилийн богд орчмын хялгант хээрээр олон тоогоор тохиолдож байв.

Дагуур огдой *Ochotona dauurica* Pallas, 1776

Биеийн галбир, хэмжээ, зүс: Бие бахим, дунд зэргийн хэмжээтэй огдой. Биеийн урт 170-220 мм, тавхайн урт 25-29 мм, биеийн жин 130-160 грамм хүрнэ. Зуны зүс бүхэлдээ бор шарга, саарал, өвөл илүү цайвар, хэвлий саарал. Сүүлгүй. Чих том дугираг, цайвар эмжээртэй. Нүд бүлтгэр. Эрүүний мэдрүүл үс болох “сахал” 40-45 мм урт(Зураг 5).



Зураг 5. Дагуур огдой (*Ochotona dauurica*). Дарьганга сумын орчимд түгээмэл тохиолдох мэрэгч. Зургийг С.Түвшинтөгс

Амьдралын онцлог: Гөлчгийтэй бүдүүн эм бүлээр амьдарна, харин эр огдой ганц нэгээр ойролцоо байршин амьдарна. Үржлийн систем маргаантай. Үүе, өдөр, бүрэнхийд идэвхтэй. Элдэв үетэн, алаг өвс, улалжийн ургал болон цэцэгт хэсгээр голчлон хооллоно. Ороо нийллэг 4 сарын дунд үед болж, эм огдой 25 орчим хоног хээлээ тээдэг. Жилд 2 удаа, тааламжтай жилд 3 удаа төллөх ба нэг удаа дунджаар 5-7, заримдаа 8-10 бөмбөөлэй төрүүлнэ. Нэг

настай үржилд ордог. Ихэвчлэн өглөө, орой бүрэнхийд исгэрч дуут дохио өгөх нь түгээмэл. 4 жил хүртэл наслана.

Амьдрах орчин: Ойт болон уулын хээр, өндөр уулс, цөлөрхөг хээрийн үетэн, алаг өвст нутагт элбэг тохиолдоно.

Дагуур огдой Дарьганга орчимд доминант мэрэгч зүйл нь байдаг. Молцог элс, түүнийг эмжиж байралсан нуур усны дэрст болон бут сөөглөг хөвөөгөөр, сумын төвөөс хойд зүгт Эрээн бут, Толь түүний залгаа Хамар булаг зэрэг газруудын харганат хээрт нэн түгээмэл, мөн Нарт, Талын ухаа, Энгэрийн ухаа, зэрэг хялгант хээрт тархдаг нь судалгааны явцад тэмдэглэгдсэн.

Дагуур зурам *Spermophilus dauricus* Brandt, 1843

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрх гоолиг, харьцангуй давжаа биетэй зурам. Биеийн урт 180-230 мм, сүүлний урт 40-60 мм, тавхайн урт 30-37 мм, биеийн жин 280 грамм хүрнэ. Зоо нуруу шаргал саарал, үс бараан сортой. Биеийн хажуу бөөр, шанаа цайвар шаргал. Зулай нь нуруунаас арай бараан. Сүүлний шувтрага хэсэг хар цагаан эмжээртэй. Хойд тавхайн ул тачир, сийрэг үсээр бүрхмэл(Зураг 6).



Зураг 6. Дагуур зурам (*Spermophilus dauricus*).Шилийн богд ууланд бүртгэсэн дагуур зурам. 2013-9-29. Зургийг С.Түвшинтөгс

Амьдралын онцлог: Гөлчгийтэй бүдүүн эм бүлээр амьдарна, харин эр огдой ганц нэгээр амьдарна. Өдрийн идэвхтэй. Элдэв шавьж, ялангуяа хатуу далавчит цох, түүний авгалдайгаар түлхүү хооллодогоороо бусад зурамнаас онцлог, үетэн ургамлын ногоон ургал хэсэг, алаг өвсний үр иднэ. Бүдүүн эр

амьтан 8-р сарын эхээр, эм зурам 9-р сарын эхээр, харин залуу бодгалиуд 9-р сарын сүүлчээс дараа оны 4-р сарын дунд үе хүртэл ичнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орж, эм зурам нь 28 хоног орчим хээлээ тээж, дунджаар 8, хааяа 10-13 гөлчгий төрүүлнэ. Хоёр настайдаа бэлэг боловсорно. Бүдүүн эм зурам хойд мөч дээрээ босож, хошгирч дуут дохио өгч сэрэмжлүүлдэг.

Амьдрах орчин: Дагуур зурам элсэрхэг, хайргалаг хөрстэй, дэгнүүлт үетэнтуулын болон ухаа гүвээт хээрт идээшин амьдарна.

Судалгаагаар Дарьганга сумын зүүн урд Ганга нуураас хойш орших Шаанын ширээ орчмоос зүүн зүг Оргил, Энгэрийн ухаа хүртэл, зүүн хойш Нарт уул хүртэл газраар тал хээрт тархдагийг тогтоосон.

Үлийн цагаан оготно *Lasiopodomys brandtii* Radde, 1861

Биеийн галбир, хэмжээ, зүс: Их биеийн өнгө цайвар, элсэн саарал, бор шаргал хүртэл олон янз. Биеийн нуруу болон хажуу талын сор үсний хар бараан төгсгөл их биеийн дэвсгэр өнгөнд үл мэдэг хар цоохор судал үүсгэнэ. Хэвлий жигд цайвар. Нүд том бөгөөд байрлал нь гавлын оройн хэсэгрүү ойртоно. Сүүл харьцангуй богино, жигд цайвар шаргалдуу өнгөтэй. Тавхай богино, хумс урт. Биеийн урт 150 мм хүрэх ба сүүл 18-30 мм. Нүдний ухархай хооронд хянга илэрнэ(Зураг 7).



Зураг 7. Үлийн цагаан оготно (*Lasiopodomys brandtii*). Зургийг zhuzhiwen.zenfolio.com сайтаас авав.

Амьдралын онцлог: Саарал оготны төрөл дотор жинхэнэ өдрийн идэвхтэй цорын ганц зүйл. Том хэмжээний суурьшил үүсгэж бөөнөөр амьдарна.

Өвөлжих үлий нарийн бүтэц, зохион байгуулалттай. Тачир ургамалтай задгай газар амьдрахад зохицсон тул хойд хөл дээрээ босох, бодгаль биесийн хооронд дууны дохиолол сайн хөгжсөн зэрэг онцлог шинж илэрнэ. Ургамлын ногоон хэсгээр холлох боловч идэш тэжээлийн бүрэлдхүүн улирлаар өөрчлөгдөнө. Хавар эрт ургамлын үндэс иднэ. Өвөлд хөөө бэлтгэнэ. Үржил 4-8 сарыг хооронд үргэлжилнэ. Өвөлжсөн эм оготно 3-4 удаа төллөх ба төрөх бүрт 2-13 хүртлэх гөлчгий гаргана. Хээл тээх хугацаа 19-21 хоног. Хавар эхний ба хоёр дахь төрөлтийн залуу бодгалиуд тэр жилдээ үржилд орно. Байгальд 1.5 жил наслана.

Амьдрах орчин: Хуурай хээрийн жинхэнэ төлөөлөгч. Ойт хээр, хээр, хуурай хээрийн дагжуур хөрстэй дэрст, харганат хөндий, уулсын энгэр бэл, талын нуур, булаг шанд, голын хөндий даган амьдарна.

Дарьганга орчимд задгай, нам өвст хээрт тархдаг. Судалгааны замналын явцад Салаа булагаас хойш хээрт нэг бүл тэмдэглэв.

Хадны барагчин *Alticola semicanus* Allen, 1924

Биеийн галбир, хэмжээ, зүс: Зоо нурууны зонхилох өнгө мөнгөлөг саарал, хэвлий цайвар. Нуруу болон хэвлийн өнгөний зааг тод илэрнэ. Үсээр битүү бүрхэгдсэн сүүл жигд цагаан, цайвар саарал, хаяа дээд тал нь бараан саарал болж сүүлний дээд, доод талын өнгө ялгарна. Биеийн урт 100-140 мм, сүүл 24-38 мм, жин 28-42 грамм хүрнэ (Зураг 8).



Зураг 8. Хадны барагчин (*Alticola semicanus*). Зургийг <http://www.planet-mammiferes.org> сайтаас авав.

Амьдралын онцлог: Хоногийн турш идэвхтэй. Бүлээр амьдарна. Хад асганы захаар ил задгай газарт гарч идээшлэнэ. Асга хад, үхэр чулуун доогуур үүр засаж орогнох ба идэш тэжээлээ нөөцлөнө. Ургамлын ногоон хэсгээр голлон хооллох ба өвөл идэш тэжээлээ нөөцлөнө. Үржил 5-8 сарын хооронд

явагдана. Жилд 1-3 удаа төрнө. Нэг удаа 2-8 гөлчгий гаргана. Хавар эрт төрсөн эхний төрөлтийн эмэгчин зулзага тэр жилдээ бэлэг боловсорч үржилд орно.

Амьдрах орчин: Ойт хээр, хээрийн дунд болон намхан уулсын хад асгатай хэсгээр байршина.

Дарьганга сумын орон нутгийн хамгаалалтай Нарт ууланд тохиолдох боломжтой.

Сохдой оготно *Ellobius tancrei* Blasius, 1884

Биеийн галбир, хэмжээ, зүс: Мөч, сүүл богино, их бие зууван. Өмнөд мөч урт хумстай. Нүд жижиг, онигор, чихний дэлбэгүй. Өтгөн жигд бөгөөд торгомсог зөөлөн үстэй. Нурууны өнгө жигд бор шаргал, бор, хэвлий цайвар. Үүдэн шүд дорсгор, урагш уруулаасаа ил гарна. Газар ухах үед үүдэн шшүдний араар уруул хаагдаж амны хөндийг хамгаална. Биеийн урт 80-125 мм, сүүл 9-15мм, жин 38-60грамм(Зураг 9).



Зураг 9. Сохдой оготно (*Ellobius tancrei*).Зургийг <http://sgp.uz> сайтаас ашиглав.

Амьдралын онцлог: Газар доогуур ярган амьдрахад зохицсон оготно. Ил гарч ирэх нь ховор. Гарахдаа харанхуйд гарна. Газрын доорхи үүр хонгилдоо хонгийн турш идэвхтэй. Ургамлын үндсээр голлон хооллоно. Бүлээр амьдарна. Хээл тээх хугацаа 3 долоо хоног. Жилд 2-3 удаа төрнө. Нэг удаа 2-8 гөлчгий гаргана.

Амьдрах орчин: Уулын хээр, хээр, хуурай хээрийн дагжуур хөрстэй газар амьдарна.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Дарьганга орчмын баруун, баруун хойд хэсэгт хээрт тохиолдох боломжтой.

Цомч шишүүхэй *Allocricetulus curtatus* Allen, 1925

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрхөөрөө бусад шишүүхэйтэй төсөөтэй боловч биеэр арай том. Биеийн урт 98-150 мм, сүүлний урт 15-21 мм, хойд тавхайн урт 16-20 мм, чихний урт 14-19 мм, биеийн жин 80-95 грамм хүрнэ. Биеийн нуруун тал саарал, хэвлий цагаан. Гэвч хэвлийн үсний уг нь саарал. Сүүлний угийн сор үс нь сүүлний дунд хэсэгт хүрнэ(Зураг 10).



Зураг 10. Цомч шишүүхэй (*Allocricetulus curtatus*). Зургийг <http://www.biolib.cz> сайтаас ашиглав.

Амьдралын онцлог: Шөнийн идэвхтэй. Олон амсартай гүн биш нүхэнд орогноно. Өвөл ичээлэхгүй бөгөөд хөөө хураана. Өвслөг ургамлын үр, навч, нахиа, шавьж иднэ. Хээл тээх хугацаа 17-33 хоног. Жилд 2-3 удаа төрөх ба төрөх бүрт 5-14 гөлчгий төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл наслана.

Амьдрах орчин: Чулуурхаг хатуу хөрстэй, сийрэг ургамалшилттай заримдаг цөлд амьдарна.

Судалгааны явцад айлын гэрт орогносон байдлаар тохиолдсон. Байгаль дээр Дарьганга орчмын баруун, баруун хойд хэсэгт цөлийн хэв шинж бүхий амьдрах орчинд тохиолдох боломжтой.

Хөх шишүүхэй *Cricetulus barabensis* Pallas, 1773

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрхөөрөө бусад шишүүхэйтэй төсөөтэй боловч биеэр арай жижиг, сүүл богиновтор. Биеийн урт 85-124 мм, сүүлний урт 20-33 мм, хойд тавхайн урт 14-17 мм, чихний урт 13,5-18 мм, биеийн жин 40-60 грамм хүрнэ. Биеийн нуруун тал тод цайвар-хүрэн,

шаргал туяатай. Нурууны дагууд бараан судалтай байдгаараа содон. Чихний ирмэг цагаан эмжээртэй. Сүүлний дээд тал бараан, доод тал цайвар өнгөтэй. Тавхайн уланд сийрэг үстэй(Зураг 11).



Зураг 11. Хөх шишүүхэй (*Cricetus barabensis*). Зургийг elementy.ru сайтаас ашиглав.

Амьдралын онцлог: Шөнийн идэвхтэй. Олон амсартай гүн биш нүхэнд орогноно. Өвөл ичээлэхгүй бөгөөд хөөө хураана. Зүйл бүрийн өвслөг ургамлын үр, навч, шавьж иднэ. Жилд 2-3 удаа төрөх ба төрөх бүрт 6-8 гөлчгий төрүүлнэ.

Амьдрах орчин: Голын хөндий, хээр, ойт хээр, заримдаг цөлд байршин амьдарна.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Дарьганга орчимд голын хөндий, хээрт тохиолдоно.

Орог зусаг *Phodopus campbelli* Thomas, 1905

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрхөөрөө бусад шишүүхэйтэй төсөөтэй. Биеийн урт 67-102 мм, сүүлний урт 8-18 мм, хойд тавхайн урт 10-14 мм, чихний урт 14-16 мм, биеийн жин 14-20 грамм хүрнэ. Биеийн нуруун тал боровтор саарал өнгөтэй, нурууг дагасан нарийн хар судалтай байдгаараа содон(Зураг 12).



Зураг 12. Орог зусаг (*Phodopus campbelli*). Зургийг www.japanese-koi.co.uk сайтаас авав.

Амьдралын онцлог: Шөнийн идэвхтэй. Нүх нь энгийн бүтэцтэй, олон амсартай. Өвөлд урт хугацааны ичээнд орохгүй. Зүйл бүрийн өвслөг ургамлын үр, шавьж иднэ. Жилд 3 удаа төрөх ба төрөх бүрт 6-9 гөлчгий төрүүлнэ. Хээл тээх хугацаа 21 хоног. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл наслана.

Амьдрах орчин: Хээр болон говийн бүсэд булаг шанд, горхийн ойролцоо тохиолдох бөгөөд ялангуяа хээрт элбэг тохиолдоно.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Дарьганга орчимд хээрт тохиолдох тархалт сайтай зүйл.

Монгол чичүүл *Meriones unguiculatus* Milne-Edwards, 1867

Биеийн галбир, хэмжээ, зүс: Нуруун тал элсэн шаргал, саарлаас шаргалдуу бор, хүрэн бор. Хэвлий саарал. Хэвлийн үсний уг хар. Хумс нь бараан. Сүүлний дээд тал богино хар бараан үстэй, төгсгөлдөө хар, хар бор өнгийн цацагтай. Биеийн урт 130 мм, сүүл 100 мм хүрнэ. Бие гүйцсэн бодгалийн жин 60-73 грамм (Зураг 13).



Зураг 13. Монгол чичүүл (*Meriones unguiculatus*). Судалгааны явцад Хамар булаг орчимд тохиолдсон чичүүлийн зураг. Зургийг С.Түвшинтөгс

Амьдралын онцлог: Хоногийн турш идэвхтэй. Бүлээр амьдардаг, нийгэмч зан төрхтэй. Нийлмэл бүтэцтэй нүхэнд амьдрах ба гүн нь 150 см хүрнэ. Ургамлын янз бүрийн хэсгээр хооллох боловч зуны улиралд ургамлын ногоон хэсэг, өвөл хавар үр голлоно. Идэш тэжээлээ нөөцлөнө. Өвөл ичэхгүй. Сонор соргог амьтан. Хээл тээх хугацаа 25-30 хоног. Жилд 1-2 удаа төллөх ба төрөх бүрт 3-8 гөлчгий гаргана. Байгалийн нөхцөлд 1-2 жил наслана.

Амьдрах орчин: Говь, хуурай хээрийн бүсээр тархах ба гол мөрний хөндий дагаж ойт хээрт нэвтрэнэ. Уулын хээрт ч тохиолдоно.үет ургамал, харгана, бударгана бүхий элсэрхэг говь, хуурай хээрт хамгийн элбэг. Хот суурин газрын ойролцоо ч тохиолдоно.

Судалгаагаар Хамар булаг, Цагаан нуур, Нарт уул зэрэг газруудад тохиолдож байсан.

Гэрийн хулгана *Mus musculus* Linnaeus, 1758

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрхөөрөө бусад хулгануудтай төстэй. Биеийн урт 70-110 мм, сүүлний урт 38-102 мм, хойд тавхайн урт 13-19 мм, чихний урт 10-15 мм, биеийн жин 20-40 грамм хүрнэ. Биеийн нуруун тал харьцангуй цайвар, элсэн саарал(Зураг 14).



Зураг 14. Гэрийн хулгана (*Mus musculus*) Зургийг www.biolib.cz сайтаас ашиглав.

Амьдралын онцлог: Бүрэнхий ба шөнийн идэвхтэй боловч өдөр тохиолдоно. Байгалийн нөхцөлд гүехэн нүхэнд амьдарна. Жилийн туршид идэвхтэй. Ихэвчлэн өвслөг ургамлын үр иднэ. Хээл тээх хугацаа 20 хоног. Жилд хэд хэдэн удаа төхж төрөх бүрт ихэвчлэн 5-7, хаяа түүнээс олон гөлчгий төрүлнэ. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл насална.

Амьдрах орчин: Хот суурин газар, түүний ойролцоох өвөлжөө бууц зэрэг газар амьдарна. Байгалийн нөхцөлд амьдрахаас гадна гэр сууц, агуулахад элбэг тохиолдоно.

Дарьганга суманд элбэг тохиолдох мэрэгч.

Сибирь алагдаага *Allactaga sibirica* Forster, 1778

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрхөөхөө бусад алаг даагатай төсөөтэй боловч хэмжээний хувьд арай том. Биеийн урт 125-180 мм, сүүлний урт 172-230 мм, тавхайн урт 64-81 мм, чихний урт 36-55 мм, биеийн жин 85-170 грамм. Биеийн нуруун тал саарал туяа бүхий цайвар өнгөтэй. Гуяны цагаан толбо нь том. Сүүлний үзүүрийн цацаг үсний хар өнгөтэй хэсгийн өмнө талд цагираг маягийн цайвар үстэй, сүүлний цацгийг доод талаас нь харахад хар өнгийн үсний дундуур сүүлний дагууд байралсан нарийн цагаан зурвастай. Сүүлний үзүүр тод цагаан (Зураг 15).



Зураг 15. Сибирь алагдаага (*Allactaga sibirica*). Зургийг www.planet-mammiferes.orgсайтаас.

Амьдралын онцлог: Шөнийн идэвхтэй. 70-150 см-ийн гүнд 500 см урт нүх ухаж орогноно. Ургамлын ногоон навч, үр, буурцаг, шавьж иднэ. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд нэг удаа төрөх ба төрөх бүрдээ 3-6 зулзага төрүүлнэ.

Амьдрах орчин:Хээр, ойт хээр, хуурай хээрт голдуу байршин амьдарна. Өндөр уулын хээрээс заримдаг цөлд хүртэлх уудам орон зайд байршин амьдарна.

Дарьганга орчимд тал хээрийн амьдрах орчинд шөнө, бүрэнхийд зам гудасын дагуу түгээмэл тохиолддог зүйл. Өдөр ухсан нүх, “бумбаа”-аар нь илрүүлж болно.

Савагдаахай *Dipus saggita* Pallas, 1773

Биеийн галбир, хэмжээ, зүс:Биеийн галбир төрхөөхөө бусад алаг даагатай төсөөтэй боловч сүүл арай урт. Биеийн урт 110-158 мм, сүүлний урт 140-178 мм, тавхайн урт 55-70 мм, чихний урт 18-25 мм, чих харьцангуй богино, хоолой хэлбэртэй, биеийн жин 46-128 грамм. Биеийн нуруун тал цайвардуу элсэн шаргал өнгөтэй. Хэвлий цагаан. Сүүлний үзүүрийн цацаг сайн хөгжсөн. Бөгөөд сүүлэнд өөхөн хуримтлал байхгүй. Хойп мөчид нь 3 хуруутай. Тавхайн улны хэсэгт цайвар өнгийн урт сагсгар үстэй зэрэг энгийн шинжүүдээр бусад алагдааганаас хялбархан ялгагдана(Зураг 16).



Зураг 16. Савагдаахай (*Dipus saggita*). зургийг ebetta.blogfa.com сайтаас

Амьдралын онцлог: Шөнийн идэвхтэй. 5 м орчим гүнтэй нүх ухаж орогноно. Өвөл ичээлнэ. Зүйл бүрийн бутлаг, өвслөг ургамлын үр, ногоон хэсэг, шавьж зэргээр хооллоно. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд нэг удаа төрж 2-5 зулзага төрүүлнэ.

Амьдралын орчин: Элсэн хөрстэй говь, цөл, цөлөрхөг хээрт голдуу байршин амьдрана.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Молцог элсэнд тохиолдох боломжтой зүйл.

Нохой элбэнх *Nyctereutes procyonoides* Gray, 1834

Биеийн галбир, хэмжээ, зүс: Толгой жижиг, хошуу богино, шөвгөр. Чихний арын үс хар. Сүүл харьцангуй богино, сагалгар. Өвлийн үс бараавтар буюу бор туяа бүхий бор-саарал өнгөтэй. Нуруун төл боровтор саарал, нурууны голыг дагасан хар судалтай бөгөөд энэ судал мөрний хэсэгтээ өргөснө. Хэвлий шаравтар бор, цээж бараавтар бор. Зуны үс нь нэлээд цайвар. Биеийн урт 65-80 см, сүүлний урт 15-25 см, хойд тавхайн урт 20-23 см, биеийн жин 5-10 килограмм (Зураг 17).



Зураг 17. Нохой элбэнх (*Nyctereutes procyonoides*). Зургийг www.naturephoto.lt сайтаас авав.

Амьдралын онцлог: Бүрэнхий ба шөнийн идэвхтэй. Ганц нэгээрээ амьдардаг. Хадны ангал, чулуун дунд өөрөө нүх ухаж хоргодно. Мөн унасан бүдүүн мод болон үнэг доргоны нүхийг ашиглана. Элдэв идэштэн. Моногами. Сээр нуруугүй амьтад, загас, мэлхий, шувуу, ургамлын үр жимс, булцуу, үндэслэг иш зэргээр хооллодог холимог идэшт амьтан. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Хээл тээх хугацаа 61-70 хоног. Жилд нэг удаа төллөх бөгөөд 6-7 гөлөг төрүүлнэ. 2-3 насандаа бэлэг боловсроно. Байгалийн нөхцөлд 3-4 жил насална.

Амьдрах орчин: Нуур голын эрэг хавийн сөөгөн ширэг, шугуй, ойн зах орчмоор байршин амьдарна. Ойт хээр болон ууланд ч тохиолдоно.

Судалгааны явцад тохиолдоогүй боловч Дарьганга орчим нь тус амьтны Монгол орон дахь тархалтын хилийн өмнөд хэсэг болдог.

Хярс *Vulpes corsac* Linnaeus, 1768

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрхөөрөө үнэгтэй төстэй боловч харьцангуй жижиг биетэй. Биеийн өнгө хул шаргалдуу саарал, сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг туяатай харагдна. Сүүл богино үзүүр нь хар. Өвлийн үс тод улаан шаргал, зуны үс улбар цайвар. Биеийн урт нь 50-60 см, сүүлний урт 25-36 см, чихний урт 6-9 см, биеийн жин 2-3 кг хүрнэ (Зураг 18).



Зураг 18. Хярс (*Vulpes corsac*). Зургийг www.flickr.com/photos/paulbjones сайтаас.

Амьдралын онцлог: Голдуу бүрэнхийд гүйдэлтэй. Хярс насан туршдаа хосоор амьдарна. Жижиг мэргэгчид, шувуу, мөлхөгч, шавьж, гэрийн мал болон зэрлэг амьтдын сэг зэм иднэ. Хоёрдугаар сард ороо нь орох бөгөөд эм хярс хээлээ тээх хугацаа 50-60 хоног тээгээд дунджаар 3-6 гавар төрүүлнэ.

Амьдрах орчин: Монгол орны ихэнх нутгаар буюу тал хээр, цөлөрхөг хээрийн бүс нутгаар өргөн тархсан.

Дарьганга орчимд өргөн тархалттай зүйл. Судалгааны явцад Молцог элс, Өлзийт булаг, Талын ухаа зэрэг газруудад янз бүрийн амьдрах орчинд тохиолдож байсан.

Шар үнэг *Vulpes vulpes* Linnaeus, 1768

Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн галбир төрхөөрөө хярстай төстэй боловч харьцангуй том биетэй. Биеийн урт нь дунджаар 60-90 см, сүүлний урт 40 - 60 см, биеийн жин ойролцоогоор 6-10 кг. Сүүл урт өтгөн үстэй, үзүүр нь цагаан. Хоншоор урт, шөвгөр. Чих соотон бөгөөд үзүүр нь шовх, чихний гадна тал хар өнгөтэй. Өвлийн үс улаан шаргал, зуны үс цайвардуу саарал. Цээж хэвлий цагаан. Мөчид харьцангуй урт, бараан өнгөтэй (Зураг 19).



Зураг 19. Шар үнэг (*Vulpes vulpes*). Судалгааны үед Нарт ууланд тохиолдсон бодгаль. 2013-10-16. Зургийг С.Түвшинтөгс

Амьдралын онцлог: Өдөр шөнөгүй тохиолдох боловч голдуу эрт орой бүрэнхийд гүйдэлтэй. Ихэвчлэн тарвага, хярс, доргоны хуучин нүх, хадны ангал зэрэгт хоргодоно. Жижиг хөхтөн, ялангуяа үлийн цагаан, жижиг шувууд, мөндөл, туулай, огдой, түүнчлэн шавьж зэргээр хооллоно. Ороо хөөцөлдөөн сэрүүн бүсэд 4-р сард, говь цөлийн бүсэд 2-3 сард болно. Үржлийн хос үүсгэнэ. Хээл тээх хугацаа 49-58 хоног. Жилд 1 удаа төллөх бөгөөд дунджаар 4-6 гавар төрүүлнэ. Гаварууд намар хүртэл эхтэйгээ хамт амьдрана. Байгалийн нөхцөлд 6-7 орчим насална.

Амьдрах орчин: Монгол орны хойт хэсгийн ойт хээр, уулын тайга, өмнөд хэсгийн говь цөл, хээр, баруун хэсгийн өндөр уулын тайгын бүс зэрэгт хааяагүй тохиолдоно. Хярсг бодвол илүү чийглэг газраар тохиолдоно.

Дарьганга орчимд өргөн тархалттай зүйл. Судалгааны явцад Молцог элс, Өлзийт булаг, Шилийн богд, Нарт зэрэг газруудад янз бүрийн амьдрах орчинд тохиолдож байсан.

Саарал чоно *Canis lupus* Linnaeus, 1758


Биеийн галбир, хэмжээ, зүс: Монгол орны саарал чоно нь үл мэдэг шаргал туяа бүхий цайвар саарал зүстэй. Нурууны голыг дагасан хар бараавтар сор үстэй, бадриун зэгзгэр мөчтэй. Биеийг урт 150-160 см, сүүлний урт 35-50 см, биеийн жин 32-50 килограмм. Бие гүйцсэн чонын толгойн ясны ерөнхий урт 20-22 см. Шүд нь нэлээд том, хүчирхэг. Ялангуяа соёо сайн хөгжсөн.

Амьдралын онцлог: Ороо нийллэг өвөл ид хүйтнээр эхэлж, орооны үед нэг гичий чоныг хэд хэдэн азарган чоно дагана. Гичий чоно хээлээ 62-65 хоног

тээгээд 5-6 сард тусгайлан зассан хүх буюу хадны хонгил, агуйд дунджаар 6-8 бэлтрэг төрүүлнэ. Бэлтрэг 9-13 хонгийн дараа нүдээ нээн. Гичий чоно 4-6 долоо хоног хөхүүл байх бөгөөд үүний дараа бэлтрэгээ бор хоолонд дасгаж эхэлнэ. Саарал чоно гэрийн мал, зэрлэг туурайтань мэрэгчид, туулайтан, жижиг шувууд тэдгээрийн өндөг, ангаахай дэгдээхэй, амьтны сэг зэм, ургамлын үр жимс зэргээр хооллоно. Ихэвчлэн үүрийн харанхуйгаар гөрөөлнө. Саарал чоно байгальд 15-16 жил насална.

Амьдрах орчин: Саарал чоно туурайтан, малын бэлчээрийг дагаж улирлаар байршлаа сэлгэнэ. Гэвч ихэвчлэн хүний нөлөөнөөс зайдуу бартаа хоргодоц сайтай, хад асга бүхий өндөр уул, гүн ой тайгад байршин амьдарна. Ялангуяа бэлтрэглэх үедээ хүнээс алс зайдуу, усанд ойр, харууцтай газрыг сонгодог онцлогтой.

Тус судалгаагаар Нарт ууланд 2013-10-04 өдөр $N45^{\circ}28'21,0''$; $E113^{\circ}39'08,80''$ солбицол орчимд 1 бодгаль, 2013-10-16 өдрийн $N45^{\circ}28'23,10''$; $E113^{\circ}39'22,40''$ солбицолд 6 бодгаль, нийт 2 удаагийн ажиглалтаар тус газарт 7 чоно тэмдэглэв(Зураг 20).



Зураг 20. Нарт ууланд байршиж байгаа саарал чонын сүрэг. Нэг дор 5 чоно байсан ба ойролцоо нэг бодгаль хэвтэж байв. Зургийг С.Түвшинтөгс

Халздай дорго *Meles leucurus* Hodgson, 1847

Биеийн галбир, хэмжээ, зүс: Овог дотроо том биетэй төлөөлөгч. Бие лагс, мөч богино, хүчирхэг. Толгой шаантаг хэлбэртэй. Их бие нуруугаараа мөнгөлөг саарал, хэвлий хар. Толгой цайвар, хүрэн. Энэ суурь өнгөн дээр нүдийг дайрсан тод хар судалтай. Сор үс нь урт, ширүүн. Биеийн урт 60-90 см, сүүл 15-20 см, жин 10-18 килограмм (Зураг 21).



Зураг 21. Халздай дорго (*Meles leucurus*). Зургийн эх сурвалж www.nature.chita.ru

Амьдралын онцлог: Суусрын овгийн дотроос нийлмэл бүтэцтэй нүх ухаж, ганц нэгээр, хосоор, бүлээр амьдардаг онцлогтой. Шөнийн болон бүрэнхийн идэвхтэй. Элдэв идэштэн. Ихэвчлэн шавьж, зөөлөн биетэн, чийгийн хорхой зэргээр хооллох ба жижиг сээртэн, жимс жимсгэнээр хооллоно. Ичээнд орохын өмнө их хэмжээний өөх хуримтлуулна. Намар 10 сараас дараа оны 4 сар хүртэл ичээлнэ. Ичээндээ төрнө. Нэг төрөлтөөр 1-6 ганьс гаргана. Хээл тээх хугацаа урт. Төрсний дараахан ороо орно. Орооны үе хавраас намар хүртэл үргэлжилнэ. Далд үетэйгээ нийлээд хээл тээх хугацаа 10 сар орчим үргэлжилнэ.

Амьдрах орчин: Ойт хээр, хээр, говийн бүсээр чийглэг, нам дор газар, голын хөндий, баянбүрд бараадан амьдарна.

Дарьгангад Шилийн богд орчим, Өлзийт булаг орчмоор урьд жилүүдэд тохиолдож байсан.

Мангис дорго *Arctonyx collaris* Cuvier, 1825

Биеийн галбир, хэмжээ, зүс: Халздай дорготой төстэй боловч гахай хоншоортой, биеэр арай том. Хамраас нүд, чих болон хүзүү хүртэл үргэлжилсэн 2 хар зураастай. Нүүрний хэсэг цагаан. Тавхай, хөл болон нурууны хэсэг нь хар хүрэн. Хэнхдэг болон өмнөд тавхайн хумс цагаан, харин халздай доргонд эдгээр

нь хар өнгөтэй. Биеийн урт 31,7-74 см, сүүлний урт 9-22 см, хойт тавхайн урт 5.5-13,5 см, чихний урт 2,1-4,5 см, биеийн жин 9,7-12,5 кг (Зураг 22) .



Зураг 22. Мангис дорго (*Arctonyx collaris*). Зургийн эх сурвалж <http://www.nickgarbutt.com>

Амьдралын онцлог: Шөнийн болон бүрэнхийн идэвхтэй. Ганц нэгээрээ амьдрана. Холимог идэштэй. Ихэвчлэн чийгийн хорхой болон бусад сээр нуруугүй амьтдаар хооллох боловч ургамлын үндэс, жижиг хөхтөө амьтдаар хооллоно. Жилд нэг удаа төрж 2-4 зулзага гаргана.

Амьдрах орчин: Ойт нутгуудад байршин амьдарна.

Энэ зүйлийн амьтны талаарх тархац, популяцийн талаарх мэдээлэл Монгол оронд тун хомс бөгөөд зөвхөн 1980-аад онд уг зүйлийг Монгол орны зүүн хэсгээс олсон талаарх мэдээнээс өөр тодорхой мэдээлэл байхгүй. Дарьганга орчимд тохиолдох нэн боломжтой бөгөөд нутгийн иргэдтэй таарсан талаарх аман мэдээ байдаг.

Өмхий хүрэн *Mustela eversmanni* Lesson, 1827

Биеийн галбир, хэмжээ, зүс: Их биеийн өнгө шаргалдуу туяатай цайвар. Их биений сор үсний үзүүр хар туяатай. Хэвлий хар хүрэн, бараан, хөл нь хар, саглагдуу сүүл нь цайвар, үзүүрүүгээ хар. Биеийн урт 28-52 см, сүүл 10-18 см, жин 1,5-2 килограмм хүрнэ (Зураг 23).



Зураг 23. Өмхий хүрэн (*Mustela eversmanni*). Зургийг <http://www.abdn.ac.uk>

Амьдралын онцлог: Өдрийн болон харанхуй, бүрэнхийн идэвхтэй. Зурам, орог зусаг, шишүүхэй мэтийн жижиг мэрэгчдээр голлон хооллоно. Ижил тэжээлийн бүрэлдхүүнд сул дорой, бага насны тарвагач орно. Хооллох амьтнаа гол төлөв нүхэнд нь орж барина. Мөлхөгч, шувуудаар ч хооллоно. Үнэг, зурам, чичүүл, тарваганы хуучин нүхэнд орогноно. Идэш тэжээлээ нөөцлөнө. Ороо 2-4 сард болж, 4-5 сард 10 хүртэл гөлчгий төрүүлнэ. Хээл тээх хугацаа 35 орчим хоног.

Амьдрах орчин: Ойт хээр, хээр, уулын хээрээр хаа сайгүй тархсан амьтан. Дагжуур хөрстэй уул, толгодын энгэр, бэлээр голдуу нутаглана.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Дарьгангад тал хээрийн бүсэд тохиолддог.

Хотны үен *Mustela nivalis* Linnaeus, 1766

Биеийн галбир, хэмжээ, зүс: Суусрын овгийн хамгийн жижиг биетэй төлөөлөгч. Дулааны улиралд нуруун хэсгийн өнгө хүрэн бор, хэвлий шаравтар туяатай цагаан. Сүүл богино, жигд бор өнгөтэй. Сүүлний үзүүр хар биш. Завьж бараан толботой. Сэрүүн бүсэд хотны үений өвлийн өнгө цав цагаан болно. Тавхай уландаа үстэй. Биеийн урт 11-26 см, сүүл 2-7 см, биеийн жин 45-200 грамм (Зураг 24).



Зураг 24. Хотны үен (*Mustela nivalis* Linnaeus). Зургийн эх сурвалж <http://a-z-animals.com>

Амьдралын онцлог: Хонгийн турш идэвхтэй. Ихэвчлэн ганц нэгээрээ амьдарна. Хээл тээх хугацаа 35 орчим хоног. Оготно элбэг жил хоёр болон түүнээс ч олон төрнө. Нэг төрөлтөөр 3-12 нүдээ нээгээгүй шөлтрөг гаргана. Хадны хонгил, завсар, овоолсон чулуун дотор, нүхэнд үүр засаж орогноно. Ихэвчлэн оготноор хооллоно. Идэш тэжээлээ нөөцлөнө.

Амьдрах орчин: Ойт хээр, хээр, уулын хээрийн ил задгай газраар хаа сайгүй амьдарна. Уулархаг нутагт хад асганд элбэг.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Дарьгангад тал хээрийн бүсэд оготно элбэг газар тохиолддог.

Цагаан үен *Mustela ermine* Linnaeus, 1758

Биеийн галбир, хэмжээ, зүс: Бие урт нарийхан, туяхан. Мөч богино. Сүүл биеийн уртын гуравны нэгтэй тэнцэнэ. Үсэн бүрхүүл өтгөн боловч сахлаг биш. Зуны улиралд нуруу, биеийн хажуу тал боровтор хүрэн, хэвлий цайвар, шаргалдуу туяатай. Сүүлийн төгсгөлийн хэсэг жилийн бүх улирлын турш хар, хар хүрэн. Биеийн урт 16-38 см, сүүл 6-12 см. Биеийн жин 350 грамм хүрнэ (Зураг 25).



Зураг 25. Цагаан үен (*Mustela ermine*). Зургийн эх сурвалж www.wildlifenorthamerica.com

Амьдралын онцлог: Шөнийн болон бүрэнхийн идэвхтэй. Модонд авирч усанд сайн сэлж чадна. Модны хонгил, нүхэнд, хадны завсар, овоолсон чулуун дотор үүр засаж амьдарна. Хойд хөл дээрээ зогсож алсын бараа харах нь ил задгай газарт амьдрахад зохицсоны баталгаа юм. Хавар 3-4 сард эсвэл зуны сүүл сард ороо ордог. Хээл тээх далд үетэй. 5-6 гөлтрөг гаргадаг. Голдуу оготно, шавьж идэштэн, хулгана зэрэг жижиг хөхтөнөөр хооллоно. Хааяа гүрвэл, хоёр нутагтан,, загас шувуу зооглох нь бий.

Амьдрах орчин: Ойт хээр, хээр, уулын хээрийн ил задгай газар, хад асга, голын хөндийн бутлаг, модлог ургамалтай өтгөн шугуй, өндөр уулын тагийн бүсээр ч амьдарна.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Дарьгангад тал хээрийн бүсэд оготно элбэг газар тохиолддог.

Хээрийн солонго *Mustela altaica* Pallas, 1811

Биеийн галбир, хэмжээ, зүс: Өвлийн үсэн бүрхүүл тачир, бүрзгэр, ерөнхий зүс цайвар шаргал, хамрын үзүүрээс чихний хоорондох зай хүртэл бор саарал. Уруул эрүүн доогуураа цайвар. Зуны зүс тод шаргал. Биеийн урт 19-26 см, сүүл 8-15 см, жин 210-255 грамм (Зураг 26).



Зураг 26. <http://www.blueanimalbio.com>

Амьдралын онцлог: Өдөр шөнийн аль ч үед идэвхтэй. Жижиг хөхтөнөөр голчлон хооллоно. Хаврын эхээр ороо орно. Хээл тээх хугацаа 40 орчим хоног. Жилд нэг удаа төллөж, 5-6 сард 7-8 гөлтрөг гаргана. Мэрэгчдийн нүх, модны ёроол, хад чулуун доогуур орогноно. Хурдан харайхаас гадна мод, бутанд авирч, усанд сайн сэлнэ.

Амьдрах орчин: Ойт хээр, хээр, уулын хээрээр амьдарна. Уулын хээр, өндөр уулын асга, хадаар элбэг тохиолдоно. Голын хөндий, уулын энгэр бэлээр ойн бүсэд гүн нэвтрэнэ.

Судалгааны явцад тэмдэглээгүй хэдийч Дарьгангад хээр, уулын хээрийн бүсэд тохиолдох боломжтой

Мануул *Felis manul* Pallas, 1776.

Биеийн галбир, хэмжээ, зүс: Жижиг биетэй зэрлэг муур. Мөч богино, бахим. Биеийн урт 50-62 см, сүүлний урт 23-31 см, чихний урт 4-5 см. Биеийн жин 2,5-4,5 килограмм. Зүс саарал, ухаагаас шаравтар бидэр, толботой. Сүүл богино, хар бараан гархи маягийн хөндлөн судалтай (Зураг 26).

Амьдралын онцлог: Мануул гол төлөв бүрэнхий, шөнийн идэвхтэй. Ганц нэгээр тохиолддог, нуугдмал амьдралтай. Үлийн цагаан оготно, чичүүл, огдой, барагчин, зурам, шишүүхэй зэрэг жижиг хөхтөн амьтны зэрэгцээ мөндөл, туулайн бүжин, ятуу, жижиг шувуудаар хооллоно. Тарваганы эзэнгүй нүх, хад чулууны хонгил, ангал, жижиг агуй зэрэгт үүрлэнэ. Ороо нийллэг 2 сард болно. Хээл тээх хугацаа дунджаар 65-67 хоног. Эм мануул 3-6 ногоолой төрүүлнэ. Хоёр настай бэлэг боловсорно. Байгальд 10 хүртэл жил наслана.

Амьдрах орчин: Мануул ойт хээр, бүх хэв шинжийн хээр, хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутаг, говь цөлийн хадат уулсаар тохиолдоно. Хуурай, гандуу задгай нутагт байршижтай.

Уг судалгаагаар Шилийн богд уул орчимд хялгант хээрийн амьдрах орчинд нэг бодгали тохиолдсон. Зураг болоод биеийн хэмжилтүүдийг хийж буцааж тависан болно (Зураг 26).



Зураг 26. Судалгааны үед Шилийн богд уул орчмын хялгант хээрийн бүлгэмдэлд тохиолдсон мануул. Зургийг С.Түвшинтөгс


Бор гөрөөс *Capreolus pygargus* Pallas, 1771

Биеийн галбир, хэмжээ, зүс: Өнгө хувьсамтгай, өвлийн улиралд их биеийн өнгө бараан саарал, толгой, нуруу, биеийн хажуу тал бор шаргал, хэвлий болон хөлний дотор тал цайвар шаргал. Зуны зүс биеийн бүх хэсэгтээ нэгэн жигд тод улаан шаргал. Тана цагаан. Тана өвөл тодорч зуны улиралд бүдэгрэнэ. Биеийн урт 127-137 см, жин 28-40 кг. Дөнгөж төрсөн янзага 1.4-2.5 кг. Янзаганы нуруугаар толботой. Гурын эвэр суурь хэсгээрээ бахим бөгөөд дунджаар 28-33, эврийн далайц 17-26 см, бие гүйцсэн гур гурван салаа эвэртэй. Толгойн яс нарийхан, сонсголын хэнгэрэг товойж гарсан байна.

Амьдралын онцлог: Идэш тэжээлд нь хоёр үрийн талт өвслөг болон модлог ургамал зонхилох ба нэг үрийн талт ургамлыг өвөл иднэ. зүр 6-7 сард 1-2 янзага төрүүлнэ. Ороо хөөцөлдөөн 7-8 сард болно.

Амдрах орчин: Бор гөрөөсний тархалтын өмнөд зах ойн бүсийн өмнөд хилтэй давхцах ба манай орны зүүн хязгаарт бутлаг ургамал, одой хус, бургас, өндөр өвс, зэгстэй голын хөндий, нуурын эрэг даган хээрийн бүсрүү гүн нэвтэрнэ.

Судалгаагаар Шилийн богдын дурсгалт газарт ихэр янзагатай эм бор гөрөөс тохиолсон бөгөөд аман мэдээгээр тэр орчимд 7 бодгальтай бор гөрөөсний сүрэг байршдаг бана (Зураг 28).



Зураг 28. Шилийн богд уулан дахь ихэр янзагатай бор гөрөөс. 2013-9-29. Зургийг С.Түвшинтөгс

Дарьгангын байгалийн цогцолборт газрын Цагаан зээр (*Procapra gutturosa* Pallas, 1777)-ны тархац нөөцийн судалгаа


Биеийн галбир, хэмжээ, зүс: Биеийн гадаад төрхөөхрөө хар сүүлт зээртэй төстэй. Зуны улиралд нуруу болон хажуу тал шаргалдуу, хэвлий цагаан. Харин өвлийн үс 3-5 см урт, өтгөн цайвар. Ооно эвэртэй. Биеийн урт 105-148 см, сэрвээний өндөр 62-84 см, сүүлний урт 9-12 см, чихний урт 9.5-12 см, биеийн жин 29-39 килограмм.

Амьдралын онцлог: Нам уулсаар олон толгойгоор сүрэглэнэ. голдуу үет ургамал, шаваг иднэ. Ус болон бэлчээрийн хомсдолоос шалтгаалан байршлаа сэлгэнэ. Ороо нийллэг 11 сарын дунд үеэс 1 сарын сүүлч хүртэлх хугацаанд болно. Нэг ооно олон шаргачинг хээлтүүлнэ. Хээл тээх хугацаа 180 хоног. Шаргачин 6-7 сард голдуу нэг, хааяа ихэр янзага төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 6-7 жил насална. 2 настайгаас бэлэг боловсроно.

Амдрах орчин: Намхан уул толгод, гүвээ бүхий хялганат хээрт байршин амьдарна.

Дарьгангын байгалийн цогцолборт газрын хялгант хээрээр цагаан зээр байнга байршин амьдардаг. Намар бэлчээр дагаж тус бүс нутгийн хойд болон

зүүн хэсгээр хялганат хээрээр их хэмжээний тоотойгоор сүрэглэн орж ирдэг. Энэ жилийн хувьд нутгийн хойд хэсэг Нартын уул, Хамрын хажуу орчмоор зээрийн томоохон сүрэг хэсэг хэсгээрээ ихээхэн саринасан байдалтайгаар 9 сараас хойш байршиж байсан (Зураг 30). Харин өмнөх жилүүдэд том хэмжээний сүрэг орж ирдэг байсан нутгийн зүүн хэсэгт цагаан зээрийн ганц нэгхэн цөөн тооны бодгальтай сүрэг судалгааны замналд тааралдаж байв. Иймд судалгааг цагаан зээрийн цөм сүрэг тархсан Нарт ууланд 2 удаагийн давталттайгаар талбайн тооллогийн аргаар тоог гаргав. Судалгааны ажиглалтын цэг $N45^{\circ}28'23,1''$, $E113^{\circ}39'22,4''$ солбицол дээр д.т.д 1290 метрийн өндөрт байралсан. Судалгааны эхний давталтыг 2013-10-4 хийсэн ба Нарт уулын өмнөд бэлээр 710 орчим тоотой сүрэг тохиолдсон бөгөөд энэ сүргийн 110 нь тухайн жилийн төл янзага байв. Харин уулын бие болон хойд ширээгээр томоохон боловч хэсэг хэсэг саринсан байдлаар 4000 –аас их зээр тоолов. Харин 2 дахь удаагийн тооллогыг 10 сарын 16 өдөр хийж гүйцэтгэсэн. Тус ажиглалтаар уулын урд бэлд 530 орчим тоотой сүрэг тоолсон бол Нартын хойд бие, Хойд ширээгээр урьд тоологдсон хэмжээний 3700 орчим тоотой, хэсэг хэсгээр тарж байрласан цагаан зээрийн сүрэг байршиж байв. Судалгааны нэгдсэн үр дүнг 2 удаагийн ажиглалтын дунджаар авч үзвэл Нарт уул орчимд их бага хэмжээтэй олон тооны сүргээс бүрдсэн -+ 240 хэлбэлзэлтэй 4470 орчим тооны цагаан зээрийн нөөцтэй гэсэн үр дүн гарч байна.




Зураг 30. Нарт ууланд байршиж байгаа цагаан зээрийн сүргийн хэсэг. 2013-10-16. Зургийг С.Түвшинтөгс

Дарьгангын байгалийн цогцолборт газрын Монгол тарвага (*Marmota sibirca* Radde, 1862)-ны тархац нөөцийн судалгаа

Манай оронд 2 зүйл тарвага байдгаас энэ бүс нутагт тархсан нь Монгол тарвага (*Marmota sibirca*) юм.

Монгол тарвага талархаг болон нам ухаа, гүвээрхэг хээр, уулын хээр, ойт хээр өндөр уулын хажуу бэл, таг, уулсын жалга судаг дагаж үетэн, элдэв алаг өвст хээрт амьдрана. Бүлээр амьдардаг бөгөөд нэг бүлд дунджаар 3-7 бодгаль амьдардаг зарим өнөр бүлд 13 хүртлэх тооны бодгаль байх нь бий. Өдрийн идэвхитэй агаад ургамлын ургал хэсгээр хооллодог. Намар 10 сард ичээнд орж, хавар 3 сард ичээнээс гарна. Эм тарвага 5-7 мөндөл төрүүлдэг. Байгалийн нөхцөлд 9-10 орчим жил наслана (Батсайхан нар, 2010).

Дарьгангын байгалын цогцолборт газрын хэмжээнд монгол тарваганы сүүлчийн нөөц тархсан Энгэрийн-Ухаа, Талын-Ухаа, Тариалан, Шилийн Богд, Улаан уул зэрэг газарт нийт 55 идэвхитэй нүх, ичээ тооллов (Хавсралт 1). Энгэрийн-Ухаа, Талын-Ухаа, Тариалан зэрэг газарт 31, Шилийн Богд орчимд 19 идэвхитэй нүх, ичээ бүртэглээ (Зураг 31ба 32).




Зураг 31. Энгэрийн-Ухаа, Талын-Ухаа, Тариалан зэрэг газруудад бүртгэгдсэн монгол тарваганы дошны тархалтын зураг.

Энгэрийн ухаа, Талын ухаа, Тариалан орчимд 11 км^2 талбайд 31 дош бүртгэсэн ба энэ орчимд 90-120 орчим монгол тарвагатай байх нөөц гарч байна. 1 км^2 талбайд 2,8 дош ноогдож байгаа бөгөөд мөн 1 км^2 талбайд 9 бодгаль ноогдох нягтшилтай байна. Бидний судалгаа хугацааны хувьд нэлээд орой хийгдсэн учир нийт бүлийн 61% ичсэн (График 1). Иймд тарваганы нөөцийн нагай (эм тарвага), хотил, мөндөлийн эзлэх хувийг гаргах боломж бүрдсэнгүй.



График 1. Энгэрийн ухаа, Талын ухаа, Тариалан орчмын монгол тарваганы ичэлтийн байдал.

Шилийн богд уулын царны хэсэгт 150 м^2 талбайд 16 дош бүртгэсэн. Бага талбайд өндөр нягтшилтай тархсанч энэ орчимд уулын зүүн урд хэсгээс бусад газарт дош илэрсэнгүй. Нийт бүлийн 26% ичээгүй байна (График 2).



Зураг 32. Шилийн богд ууланд бүртгэгдсэн монгол тарваганы дошны тархалтын зураг.

Шилийн Богд ууланд 200 м² талбайд нийт 19 бүл, 60-76 орчим тоо толгой бүхий тарваганы нөөц гарч байна. Энэ уул нь сүсэг бишрэлтэй холбоотойгоор мөн жуулчид их ирдэг, сум орон нутгаас зайдуу зэрэг шалтгаанаар дээрх тарваганы популяци тогтвортой орших боломж бий.



График 1. Шилийн Богд уулын монгол тарваганы ичэлтийн хувь.

Судалгааны явцад Дарьганга сумын төвөөс 61 км зайтай, Шилийн Богд уулнаас 7 км зайд орших Улаан уул гэдэг газраас хоолой дагасан монгол тарваганы 5

идэвхитэй дош илрүүлж бүртгэсэн (Зураг 33). Энэ орчимд 90 м²талбайд 20 орчим бодгалийн нөөцтэй байна.



Зураг 33. Улаан уул орчимд тэмдэглэгдсэн эртний голын ул мөр болсон хоолойноос шинээр илрүүлсэн монгол тарваганы идэвхитэй дошны тархалтын зураг.

Цогцолборт газрын хэмжээнд авж үзхэд нийт 170-200 тоо толгой бүхий монгол тарвага 11,3 км²талбайд тархсан нөөцтэй байна. Тархсан талбайдаа 100 м² тутамд 0,6 бодгаль буюу 200 м²талбайд 1 бодгаль ноогдох нягтшилтай байна. Мөн энэ бүс нутагт тархсан монгол тарваганы ичэх хугацаа харьцангуй эрт буюу 9 сарын 26 гэхэд нийт бүлийн 50 орчим хувь нь ичиж, 16% нь муу нүх, зусаал нүхүүдээ бөглөж эхэлсэн нь судалгаагаар харагдаж байна (График 3).



График 3. Цогцолборт газрын хэмжээнд нийт тарваганы бүлийн ичэлтийн байдлыг харуулсан үр дүн.

Жижиг хөхтөн амьтны зүйлийн бүрдэлийн судалгаа

Бидний энэхүү судалгаа нь 2013 оны 9 сарын 25 –д эхэлсэн бөгөөд цаг хугацааны хувьд хэтэрхий оройтсон мэрэгч амьтдын хувьд идэвхи ихэд буурсан үе байлаа. Үүнэтэй холбоотойгоор дээжинд цөөн зүйлийн цөөн бодгаль баригдсан. Дээжийг ашиглаж экологийн судалгааны аливаа үр дүнг боловсруулхад ихээхэн учир дутагдалтай байлаа. Судалгаагаар ялгаатай амьдрах орчнуудаас жижиг хөхтөн амьтны нийт 6 овгийн 7 төрөлд хамаарах 7 зүйлийн 8 бодгаль дээжинд авсан (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Ялгаатай амьдрах орчинуудаас барисан жижиг хөхтөний зүйлийн жагсаалт

	Овог	Монгол нэр	Латин нэр	Тоо	Амьдрах орчин
1	Ochotonidae	Дагуур огдой	<i>Ochotona dauurica</i>	2	Харганат хээр болон элст
2	Scuridae	Дагуур зурам	<i>Spermophilus daurivus</i>	1	Хээр
3	Cricetidae	Цомч шишүүхэй	<i>Alloricetulus curtatus</i>	1	Хээр
4	Cricetidae	Шишүүхэй	<i>Cricetulus sp</i>	1	Нура
5	Gerbilidae	Монгол чичүүл	<i>Meriones unguiculatus</i>	1	Хээр
6	Muridae	Гэрийн хулгана	<i>Mus musculus</i>	1	Хээр
7	Dipodidae	Сибирь алагдаага	<i>Allactaga sibirica</i>	1	Хээр

Дээжинд баригдсан нийт жижиг хөхтөний зүйлүүдийн 75% нь хээрийн амьдрах орчныг шүтэж оршиж байна. Мөн цогцолборт газрын хэмжээнд авч үзвэл хээрийн амьдрах орчинд жижиг хөхтөний зүйлийн олон янз байдал хамгийн их байгаа нь харагдаж байна.

Судалгаагаар баригдсан нийт хөхтөн амьтдын биеийн урт, сүүлний урт, тавхайн урт, чихний өндөр зэрэг хэмжилтүүдийг хийж мэдээлэлийг хавсаргав (Хүснэгт 4). Гавлын яс болон арьсаар цуглуулга хийсэн (Зураг 34) ба энэ нь дараа дараагийн судалгааны ажилд ихээхэн ач холбогдол өгөөд зогсохгүй тухайн зүйлүүдийн талаарх хэрэгцээт мэдээлэлийг өгөх чухал баримт болдог.



Зураг 34. Судалгаагаар дээжинд авсан зарим мэрэгчдийн арьс болон гавлын ясны цуглуулга.

Цогцолборт газрын шувуудын зүйлийн бүрдэл

Дарьганга сум болон Дарьгангын байгалийн цогцолборт газрын хэмжээнд 24 овгийн 94 төрөлд хамаарах 175 зүйл шувуу бүртэгдлээ (Хүснэгт 4). Нийт шувуудын зүйлүүдийг зөвхөн тус бүс нутагт тохиолдох байдлаар авч үзэхэд Зусдаг 15, Нүүдлийн зусдаг 10, Суурин 18, Нүүдлийн үедээ тохиолддог 129, Өвөлжих үедээ орж ирдэг 5 зүйл шувуу байна. Судалгааны явцад тус газарт хийгдсэн өмнөх судалгааны ажлаар бүртгэгдээгүй Цагаан дэглий (*Egretta alba*), Номин гургалдай (*Luscinia cyane*) зэрэг 2 зүйл болон өмнөх жилийн ажиглалтаар Бүртгэсэн Соотон гуйванга (*Asio otus*), Хар өрөвтас (*Ciconia nigra*) зүйлийг шинээр нэмж цогцолборт газрын шувуудын зүйлийн бүрдлийг баяжууллаа (Зураг 35).

Хүснэгт 4. Дарьганга сум болоод Дарьгангын байгалийн цогцолборт газар бүртгэгдсэн шувуудын зүйлийн бүрдэлийн жагсаалт. Зөвхөн тус бүс нутагт тохиолдох байдлаар нь доорх байдлаар ангилсан болно. 3-зусдаг, С-суурин, НҮТ-нүүдлийн үедээ тохиолддог, НЗ-нүүдлийн зусдаг, ӨҮОИ- өвөлжих үедээ орж ирдэг.

№	Латин нэр	З	С	НҮТ	НЗ	ӨҮОИ
1	<i>Perdix dauurica</i>		+			
2	<i>Anser cygnoides</i>			+		
3	<i>Anser fabalis</i>			+		
4	<i>Anser albifrons</i>			+		
5	<i>Anser anser</i>			+		
6	<i>Anser indicus</i>			+		
7	<i>Cygnus Cygnus</i>	+				
8	<i>Todorna feruginea</i>	+				
9	<i>Todorna todorna</i>	+				
10	<i>Anas strpera</i>	+				
11	<i>Anas penelope</i>			+		
12	<i>Anas platyrhynchos</i>			+		
13	<i>Anas clypeata</i>			+		
14	<i>Anas acuata</i>			+		
15	<i>Anas querquedula</i>			+		
16	<i>Anas crecca</i>			+		
17	<i>Aythya ferina</i>			+		
18	<i>Aythya fuligula</i>			+		
19	<i>Bucephala clangula</i>			+		
20	<i>Mergellus albellus</i>			+		
21	<i>Podiceps cristatus</i>			+		
22	<i>Platalea leucorodia</i>			+		
23	<i>Ardea cinerea</i>			+		
24	<i>Phalacrocorax carbo</i>			+		
25	<i>Falco naumanni</i>			+		
26	<i>Falco tinnunculus</i>					+
27	<i>Falco amurensis</i>			+		
28	<i>Falco columbarius</i>			+		
29	<i>Falco subbuteo</i>			+		

30	<i>Falco cherrug</i>					+
31	<i>Milvus migrans</i>			+		
32	<i>Gypaetus barbatus</i>		+			
33	<i>Gyps himalayensis</i>			+		
34	<i>Aegypius monachus</i>					+
35	<i>Circus cyaneus</i>			+		
36	<i>Accipiter nisus</i>			+		
37	<i>Accipiter gentilis</i>					+
38	<i>Buteo buteo</i>			+		
39	<i>Buteo hemilasius</i>	+				
40	<i>Aquila nipalensis</i>	+				
41	<i>Aquila heliaca</i>			+		
42	<i>Aquila chrysaetos</i>		+			
43	<i>Otis tarda</i>			+		
44	<i>Fulica atra</i>			+		
45	<i>Grus vipo</i>			+		
46	<i>Anthropoides vigro</i>	+				
47	<i>Grus grus</i>			+		
48	<i>Himantopus himantopus</i>			+		
49	<i>Recurvirostra avosette</i>			+		
50	<i>Vanellus vanellus</i>			+		
51	<i>Pluvialis fulva</i>			+		
52	<i>Charadrius dubius</i>			+		
53	<i>Charadrius alexandrinus</i>			+		
54	<i>Charadrius leschenaultii</i>			+		
55	<i>Charadrius veredus</i>			+		
56	<i>Gallinago stenura</i>			+		
57	<i>Gallinago gallinago</i>			+		
58	<i>Limosa limosa</i>			+		
59	<i>Numenius numenius</i>			+		
60	<i>Tringa erythropus</i>			+		
61	<i>Tringa tetanus</i>			+		
62	<i>Tringa stagnatilis</i>			+		
63	<i>Tringa nebularia</i>			+		
64	<i>Tringa ochropus</i>			+		
65	<i>Tringa glareola</i>			+		
66	<i>Xenus cinereus</i>			+		
67	<i>Actits hypoleucos</i>			+		
68	<i>Arenaria interpres</i>			+		
69	<i>Calidris minuta</i>			+		
70	<i>Calidris ruficollis</i>			+		
71	<i>Calidris temminckii</i>			+		
72	<i>Calidris subminuta</i>			+		
73	<i>Calidris acuminata</i>			+		
74	<i>Calidris ferruginea</i>			+		
75	<i>Limicola falcinellus</i>			+		
76	<i>Larus mongolicus</i>			+		
77	<i>Larus ridibundus</i>			+		

78	<i>Sterna hirundo</i>			+		
79	<i>Chlidonias leucopterus</i>			+		
80	<i>Syrrhaptes paradoxus</i>		+			
81	<i>Columba livia</i>		+			
82	<i>Columba rupestris</i>		+			
83	<i>Streptopelia orientalis</i>			+		
84	<i>Streptopelia decaocto</i>			+		
85	<i>Cuculus canorus</i>			+		
86	<i>Cuculus saturatus</i>			+		
87	<i>Bubo bubo</i>		+			
88	<i>Athene noctua</i>		+			
89	<i>Asio flammeus</i>					+
90	<i>Apus apus</i>	+				
91	<i>Apus pacificus</i>			+		
92	<i>Upupa epops</i>	+				
93	<i>Jynx torquilla</i>			+		
94	<i>Lanius isabellinus</i>			+		
95	<i>Lanius cristatus</i>	+				
96	<i>Lanius excubitor</i>					+
97	<i>Pyrrhocorax pyrrhocorax</i>		+			
98	<i>Corvus dauuricus</i>			+		
99	<i>Corvus frugilegus</i>			+		
100	<i>Corvus corone</i>		+			
101	<i>Corvus corax</i>		+			
102	<i>Riparia riparia</i>			+		
103	<i>Hirundo rustica</i>	+				
104	<i>Delichon urbicum</i>			+		
105	<i>Myiophobus mongolica</i>		+			
106	<i>Calandrella brachydactyla</i>	+				
107	<i>Calandrella cheleensis</i>	+				
108	<i>Calerida cristata</i>					+
109	<i>Alauda arvensis</i>			+		
110	<i>Eremophila alpestris</i>		+			
111	<i>Locustella certhiola</i>			+		
112	<i>Acrocephalus aedon</i>			+		
113	<i>Phylloscopus collybita</i>			+		
114	<i>Phylloscopus fuscatus</i>			+		
115	<i>Phylloscopus proregulus</i>			+		
116	<i>Phylloscopus borealis</i>			+		
117	<i>Phylloscopus trochiloides</i>			+		
118	<i>Sturnus cineraceus</i>			+		
119	<i>Zoothera dauma</i>			+		
120	<i>Turdus obscurus</i>			+		
121	<i>Turdus ruficollis</i>			+		+
122	<i>Luscinia calliope</i>			+		
123	<i>Tarsiger cyanurus</i>			+		
124	<i>Phoenicurus phoenicurus</i>			+		
125	<i>Phoenicurus aureus</i>			+		

126	<i>Saxicola torquatus</i>			+		
127	<i>Oenanthe oenanthe</i>			+		
128	<i>Oenanthe pleschanka</i>			+		
129	<i>Oenanthe deserti</i>	+				
130	<i>Oenanthe isabellina</i>	+				
131	<i>Monticola saxatilis</i>			+		
132	<i>Muscicapa striata</i>			+		
133	<i>Muscicapa dauurica</i>			+		
134	<i>Ficedula albicilla</i>			+		
135	<i>Passer domesticus</i>		+			
136	<i>Passer montanus</i>		+			
137	<i>Petronia petronia</i>		+			
138	<i>Pyrgilauda davidiana</i>		+			
139	<i>Prunella montoanella</i>			+		
140	<i>Motacilla alba</i>			+		
141	<i>Motacilla citreola</i>			+		
142	<i>Motocilla flava</i>			+		
143	<i>Motocilla cinerea</i>			+		
144	<i>Anthus richardi</i>			+		
145	<i>Anthus campestris</i>			+		
146	<i>Anthus godlewskii</i>			+		
147	<i>Anthus hodgsoni</i>			+		
148	<i>Anthus spinoletta</i>			+		
149	<i>Fringilla montifringilla</i>			+		
150	<i>Carduelis flammea</i>					+
151	<i>Carduelis flavirostris</i>			+		
152	<i>Carpodacus erythrinus</i>			+		
153	<i>Coccothraustes coccothraustes</i>					+
154	<i>Emberiza leucocephalos</i>			+		
155	<i>Emberiza fucata</i>			+		
156	<i>Emberiza pusilla</i>			+		
157	<i>Emberiza aureola</i>			+		
158	<i>Emberiza spodocephala</i>			+		
159	<i>Emberiza pallasi</i>			+		
160	<i>Emberiza schoeniclus</i>			+		
161	<i>Calcarius lapponicus</i>				+	
162	<i>Podiceps auritus</i>			+		
163	<i>Podiceps nigricollis</i>			+		
164	<i>Turdus naumanni</i>			+		
165	<i>Phylloscopus inornatus</i>			+		
166	<i>Aygylos caudatus</i>				+	
167	<i>Pica pica</i>		+			
168	<i>Carduelis spinis</i>			+		
169	<i>Carduelis sinica</i>			+		
170	<i>Dendrocopos major</i>				+	
171	<i>Cygnus columbianus</i>			+		
172	<i>Egretta alba</i>			+		

173	<i>Luscinia cyane</i>			+		
174	<i>Asio otus</i>				+	
175	<i>Ciconia nigra</i>			+		
	Бүгд	15	18	128	4	10
		175				



Зураг 35. Дарьганга орчимын шувуудын зүйлийн бүрдэлд шинээр бүртгэсэн Соотон гуйванга, Номин гургалдай зэрэг 2 зүйлийн шувуудын зураг. Зургийг С.Түвшинтөгс

Судалгааны явцад бүртгэсэн ховор шувуудын жагсаалт.

Монгол нэр	Латин нэр	Бүртгэсэн газар	Тоо	БНС	ОУС
Хошуу галуу	<i>Anser cygnoides</i>	Ганга, Дуут	40<	ХБ	Э
Цэн тогоруу	<i>Grus vipio</i>	Ганга, Дуут	38	Э	Э
Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	Өлгий хад	1	Э	Э

Тайлбар: БНС- бүс нутгийн статус, ОУС-олон улсын статус, ХБ-ховордож болзошгүй, Э-эмзэг.



Зураг 36. Ганга нуурын урд бүртгэсэн Цэн тогорууд, 2013-10-5. Нийт 14 бодгаль байсан ба 3 нь тухайн жилийн ангаахай (залуу шувуу) байв. Зургийг С.Түвшинтөгс

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дарьгангын байгалийн цогцолборт газарт хийсэн зэрлэг амьтдын зүйлийн бүрдэл, тархац элбэгшлийг тогтоох судалгаагаар дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

1. Тус бүс нутагт хийгдсэн судалгааны ажил хангалтгүй байгаа учир мэргэжлийн байгууллага, судлаач нартай хамтран мэрэгчид, гар далавчтан, жижиг махчид зэрэг амьтдын төрөлжсөн болон нэгдсэн судалгааг хийх.
2. Дарьгангын байгалийн цогцолборт газар тус бүс нутагт тархсан амьтдын толгойн яс (ялангуяа жижиг хөхтөн, гар далавчтан), арьс зэргээр цуглуулгын сан бий болгох. Энэ нь дараа дараагийн судалгаанд чухал ач холбогдолтой байдаг
3. Тус бүс нутагт тархдаг эсэх нь тодорхойгүй болон судалгааны явцад илрээгүй сохдой оготно, хадны барагчин, шар чичүүл зэрэг бусад амьтдын талаар мэдээлэл цуглуулах, шаардлагатай бол судалгаа хийх
4. Монгол орны хэмжээнд мэдээлэл хангалтгүй байгаа Мангис дорго тус бүс нутагт тархдаг талаарх мэдээ, баримт олох болон цуглуулга хийх
5. Цогцолбор газрын захиргаа судалгааны багаж, хэрэгсэлтэй болох жишээ нь: амьд баригч, конус, гар далавчтан болон, жижиг шувууд барих боломжтой тор гэх мэт.
6. Ганга нуур болон бусад нуруудад чуулж байгаа Гангар хунгийн тоог жил бүр тогтмол бодитойгоор гарагж олон жилийн мониторинг судалгааны мэдээ бүрдүүлэх
7. Аливаа судалгааны ажлыг цаг хугацааны хувьд тохиромжтой үед нь гүйцэтгэж байх

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын үр дүнгээр гарсан гол ач холбогдолтой үр дүншүүдийг дүгнэж гаргавал.

Хэвлэгдсэн бүтээл болон энэхүү судалгааны ажлын явцад бүртгэсэн амьтдын зүйлүүдийг нэгтгэвэл Дарьгангын байгалийн цогцолборт газрын хэмжээнд 39 зүйл амьтан тохиолдох боломжтой байна.

Хэвлэгдсэн бүтээл, эх сурвалжуудад энэ нутагт тэмдэглэгдээгүй Аргаль (*Ovis ammon*), Хулан (*Equus hemionus*) зэрэг 2 зүйл хөхтөн амьтдыг судалгаагаар бүртгэсэн бөгөөд Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) өвлийн улиралд тус бүс нутагт цөөн тооны сүргээр нүүдэллэн орж ирдэгийг тогтоов.

Цогцолборт газар тархсан нийт амьтдын 24% нь бүс нутгийн хэмжээнд ховор, харин олон улсын хэмжээнд 11% нь ховордлийн зэрэгт хамаарагдаж байна.

Дарьганга сум болон Дарьгангын байгалийн цогцолборт газрын хэмжээнд тохиолдох боломжтой нийт 175 зүйл шувуудын жагсаалт гаргалаа. мөн олон улсын болоод бүс нутгийн хэмжээнд ховордсон зарим шувууд нүүдлийн үедээ цогцолборт газрыг олон тоогоор дамжин өнгөрдөг нь тогтоогдож байна.

Судалгаагаар тус газарт хийгдсэн өмнөх судалгааны ажлаар бүртгэгдээгүй Цагаан дэглий (*Egretta alba*), Номин гургалдай (*Luscinia cyane*), Соотон гуйванга (*Asio otus*), Хар өрөвтас (*Ciconia nigra*) зэрэг зүйлүүдийг шинээр нэмж цогцолборт газрын шувуудын зүйлийн бүрдлийг баяжууллаа.

Цогцолборт газрын хэмжээнд авж үзхэд нийт 170-200 тоо толгой бүхий монгол тарвага 11,3 км² талбайд тархсан нөөцтэй байна. Тархсан талбайдаа 200 м² талбайд 1 бодгаль ноогдох нягтшилтай байна.

Мөн энэ бүс нутагт тархсан монгол тарваганы ичэх хугацаа харьцангуй эрт буюу 9 сарын 26 гэхэд нийт бүлийн 50 орчим хувь нь ичдэг байна.

Ашигласан ном

1. Аттэ Комонэн. 2001. Экологи. Дорнод монголын биологийн төрөл зүйл төсөл. Чойбалсан.
2. Батсайхан Н., Самъяа Р., Шар С., С.Р.Б Кинг. 2010. Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага. Лондоны амьтан судлалын нийгэмлэг. Лондон.
3. Болдгив Б., Батсайхан Н. 2007. Экологийн нэр томъёоны Англи-Монгол толь. Улаанбаатар.
4. Ганхуяг П., Болормөнх Э., Амархүү Г. 2012. Ганга нуур ба түүний орчмын шувуудын намрын нүүлийн ажиглалтын үр дүгнээс. Зэрлэг амтан судлах хамгаалах төв. Улаанбаатар.
5. Дуламцэрэн С. 1970. Монгол орны хөхтөн амьтан тодорхойлох бичиг. Шинжлэх Ухаан Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар.
6. Самъяа Р., Лхагвасүрэн Д., Шар С., 2003. Хөхтөн амьтдыг толгойн ясны шинжээр тодорхойлох түлхүүр. Улаанбаатар
7. Туяа Ц, Мижиддорж Б, Адъяа Яд, Мөнхцог Б. 2005. Байгаль хамгаалагчийн гарын авлага. Улаанбаатар
8. Цогтсайхан П., Пүрэвсүрэн Т., Чимэддорж Б., 2012. Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны арга зүй. Улаанбаатар.
9. Шар С., Самъяа Р., Гомбобаатар С., Цэвээнмядаг Н., Цагаанцоож Н., Тунгалаг Р., 2008. Богдхан уул, түүний орчмын зонхилох амьтан ургамал. Улаанбаатар
10. Gombobaatar, S. and Monks, E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J.E.M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors) (2011). Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society.

Хавсралт 1.

Дарьгангын байгалийн цогцолборт газрын Тариалан, Энгэрийн ухаа, Талын ухаа зэрэг газруудад тархсан Монгол тарваганы идэвхтэй нүх, ичээний байршилийн мэдээлэл

Site name	N	E	Elevation (m)	Date	Note
Tar Dosh 1	45°21'40.0"	114°09'08.8"	1361	26-Sep-13	ichsen
Tar Dosh 2	45°21'48.3"	114°09'04.1"	1359	26-Sep-13	ichsen
Tau Dosh 3	45°22'01.5"	114°09'31.7"	1371	26-Sep-13	ichsen
Tau Dosh 4	45°22'02.3"	114°09'42.4"	1379	26-Sep-13	ichsen
Tau Dosh 5	45°21'49.2"	114°09'34.1"	1377	26-Sep-13	nuhee bogolj ehelsen
Tau Dosh 6	45°21'49.4"	114°09'37.6"	1375	26-Sep-13	ichsen
Tau Dosh 7	45°22'07.3"	114°09'18.1"	1368	26-Sep-13	nuhee bogolj ehelsen
Tau Dosh 8	45°22'23.5"	114°09'23.5"	1373	26-Sep-13	nuhee bogolj ehelsen
Tar Dosh 9	45°21'32.6"	114°09'12.4"	1375	27-Sep-13	icheegui
Tar Dosh 10	45°21'34.7"	114°09'20.4"	1377	27-Sep-13	ichsen
Tar Dosh 11	45°21'28.3"	114°09'31.0"	1382	27-Sep-13	ichsen
Tar Dosh 12	45°22'04.3"	114°09'57.4"	1377	27-Sep-13	nuhee bogolj ehelsen, 2 tarvagatai
Tar Dosh 13	45°21'50.9"	114°09'25.9"	1370	27-Sep-13	icheegui
Tar Dosh 14	45°21'49.0"	114°09'18.5"	1364	27-Sep-13	ichsen
Tar Dosh 15	45°21'54.6"	114°08'59.4"	1364	27-Sep-13	icheegui, havh tavisan bna
Tar Dosh 16	45°21'57.1"	114°08'56.5"	1351	27-Sep-13	icheegui
Tar Dosh 17	45°22'02.1"	114°08'53.8"	1362	27-Sep-13	icheegui
Tar Dosh 18	45°22'05.3"	114°09'07.0"	1360	27-Sep-13	ichsen
Tar Dosh 19	45°22'08.9"	114°09'11.3"	1363	27-Sep-13	icheegui
Tar Dosh 20	45°22'10.9"	114°09'07.7"	1359	27-Sep-13	ichsen
Enu Dosh 21	45°22'28.7"	114°08'16.7"	1340	27-Sep-13	ichsen
Enu Dosh 22	45°22'28.7"	114°08'09.3"	1349	27-Sep-13	ichsen
Enu Dosh 23	45°22'28.1"	114°07'47.3"	1357	27-Sep-13	ichsen
Enu Dosh 24	45°22'50.8"	114°08'06.3"	1362	27-Sep-13	nuhee bogolj ehelsen
Enu Dosh 25	45°22'38.3"	114°08'17.2"	1355	27-Sep-13	ichsen
Tau Dosh 26	45°23'16.0"	114°09'46.4"	1364	27-Sep-13	ichsen
Tau Dosh 27	45°23'23.4"	114°09'47.6"	1363	27-Sep-13	icheegui
Tau Dosh 28	45°22'42.3"	114°09'30.4"	1366	27-Sep-13	icheegui
Tar Dosh 29	45°22'20.0"	114°08'58.4"	1364	27-Sep-13	icheegui, havh tavisan bna
Enu Dosh 30	45°22'18.2"	114°08'18.3"	1352	27-Sep-13	ichsen
Enu Dosh 31	45°22'18.9"	114°07'48.6"	1359	27-Sep-13	ichsen

Шилийн богдын дурсгалт газарт тархсан Монгол тарваганы идэвхтэй нүх, ичээний байршилийн мэдээлэл

Site name	N	E	Elevation (m)	Date	Note
Shb Dosh 1	45°28'25.3"	114°34'53.4"	1653	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 2	45°28'20.5"	114°35'01.5"	1670	29-Sep-13	bogolson
Shb Dosh 3	45°28'22.3"	114°34'57.7"	1667	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 4	45°28'23.3"	114°35'01.5"	1672	29-Sep-13	bogolson
Shb Dosh 5	45°28'24.8"	114°35'02.3"	1672	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 6	45°28'26.8"	114°35'00.8"	1672	29-Sep-13	bogolson
Shb Dosh 7	45°28'27.2"	114°35'03.1"	1680	29-Sep-13	bogolj ehelsen
Shb Dosh 8	45°28'26.4"	114°35'04.0"	1679	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 9	45°28'24.1"	114°35'05.9"	1684	29-Sep-13	bogolj ehelsen
Shb Dosh 10	45°28'19.7"	114°35'05.1"	1671	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 11	45°28'16.1"	114°35'08.4"	1692	29-Sep-13	bogolson
Shb Dosh 12	45°28'17.2"	114°35'09.09"	1698	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 13	45°28'18.4"	114°35'10.9"	1694	29-Sep-13	bogolj ehelsen
Shb Dosh 14	45°28'20.4"	114°35'12.8"	1705	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 15	45°28'23.0"	114°35'12.9"	1703	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 16	45°28'20.4"	114°35'15.3"	1727	29-Sep-13	bogloogui
Shb Dosh 17	45°28'05.1"	114°35'31.3"	1572	29-Sep-13	bogolson
Shb Dosh 18	45°28'06.1"	114°35'33.1"	1571	29-Sep-13	bogolj ehelsen
Shb Dosh 19	45°28'08.4"	114°35'33.2"	1585	29-Sep-13	bogloogui

Дарьгангын байгалийн цогцолборт газрын Улаан уул орчимд тархсан Монгол тарваганы идэвхтэй нүх, ичээний байршилийн мэдээлэл

Site name	N	E	Elevation (m)	Date	Note
Ulu Dosh 1	45°31'14.0"	114°33'32.3"	1425	29-Sep-13	bogolson
Ulu Dosh 2	45°31'13.2"	114°33'37.3"	1425	29-Sep-13	bogloogui
Ulu Dosh 3	45°31'06.6"	114°33'48.5"	1435	29-Sep-13	bogloogui
Ulu Dosh 4	45°31'03.0"	114°33'56.7"	1436	29-Sep-13	bogolson
Ulu Dosh 5	45°30'58.1"	114°34'02.3"	1432	29-Sep-13	bogolson